

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



**2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ
ТАЙЛАН**

Мөрөн
2022 он

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР
2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД
3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
8. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
9. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
10. ДҮГНЭЛТ

1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушалаар батлагдсан бүтэц орон тооны дагуу Төрийн захиргааны 38 үндсэн ажилтан, төрийн үйлчилгээний 5 үндсэн ажилтан, гэрээт 4 албан хаагч нийт 47 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга 1, иргэний улсын бүртгэгч 5, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 3, сумын улсын бүртгэгч 25, ахлах нягтлан бодогч 1, мэдээлэл технологийн ажилтан 1, нярав бичиг хэргийн ажилтан 1, архивч 2, гэрээт ажилтан 4 тус тус ажиллаж байна.

2022 жилийн эцэст Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан. Мөн Улсын бүртгэлийн үйл ажилагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, сумдын улсын бүртгэгч нарт холбогдох чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

2022 оны жилийн эцэст УБЕГ-ын даргын 47 тушаал, 4 зөвлөмж, 14 чиглэл, 6 албан даалгавар ирснийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 22 удаагийн цахим болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.

Хэлтсийн 38 албан хаагчийн 2021 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлант хугацаанд шинээр томилогдсон болон, албан тушаал дэвшсэн 7 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан Баталгааны маягтыг УБЕГ-т хүргүүлэн, нууцын баталгааг гаргуулан ажилласан.

Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 30 арга хэмжээг хяналтандаа авч, мөн нэмэлтээр 2 ажлыг гүйцэтгэлийн тайланд тусган хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу иргэн, хуулийн этгээдэд олгосон иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалж үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хяналт, шалгалт хийж гүйцэтгэв. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан эсэхийг шалгалаа. Шалгалтаар нийт 105 иргэн, хуулийн этгээд шалгаснаас 70 хүнсний дэлгүүр, 10 зочид буудал, 17 эм ханган нийлүүлэх газар, 4 барьцаалан зээлдүүлэх газар, 4 ТҮЦ зэрэг иргэн, хуулийн этгээдийг шалгахад ямар нэгэн зөрчил илэрсэнгүй. Дээрх иргэн, хуулийн этгээдэд энэ төрлийн зөрчил гаргахгүй байх, иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалбал “Зөрчлийн тухай хууль”-ийн 15.24-2 д заасан торгуулийн арга хэмжээ авах хууль тогтоомжийн зарим зүйл заалтын талаар мэдээ мэдээлэл өглөө.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж”-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хяналтын улсын байцаагч нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 01-нээс 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэлх бүртгэлийг шалгаж нийт 1687 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Энэхүү шалгалтаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан Хяналт шалгалтын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 дах заалтад заасан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх” ажлыг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллан тайланг илтгэх хуудсаар УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүллээ.

Тус аймгийн Галт, Тариалан, Түнэл сумын ИТХурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/284 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт тавин ажилласан бөгөөд нөхөн сонгууль бүхий сумдын сонгогчдын нэрийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох хууль, журмын хүрээнд нятлан шалгаж 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хэвлэж, тухай сумдын сонгуулийн хороонд хуулийн хугацаанд хүлээлгэн өгж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 1/8275 тоот “Гадаад паспортын хөтлөх тухай” чиглэлийн дагуу үндэсний энгийн гадаад паспортын үйлдвэр ашиглалтад орсонтой холбогдуулан 10 дугаар сарын 01-ний өдрөөс олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын /ИКАО/-ын стандарт шаардлагын дагуу гадаад паспорт захиалж байгаа иргэдийн цээж зургийг хэлтэст авах нөхцөл техник тоног төхөөрөмжийг бэлтгэн тусдаа өрөөг тохижуулан гадаад паспортын захиалгыг хүлээн авч байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/804 тоот чиглэлийн дагуу 272 иргэний ХААТР, ИУБ маягтуудын Б талыг цахимжуулан ажиллалаа.

Хэлтсийн ББНШК-ын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийн дагуу хадгалах хугацаа нь дууссан ИУБ21 9250 \баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт-30\, архиваас түр олгох бүртгэлийн дэвтэр “МАЯГТ А2” \хадгалах хугацааны жагсаалтын-47\, эд хөрөнгө бүтгэлтэй эсэх, барьцаатай эсэх лавлагаа \хадгалах хугацааны жагсаалтын-48\, захиалгын хуудас \хадгалах хугацааны жагсаалтын-49\ нэр төрлийн баримтыг комиссын гишүүд Мөрөн сумын 1-р багт байрлах Ирээдүй сургуулийн уурын зууханд шатааж устгасан.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу “Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага”, “Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” ТББ-тай хамтран “Иргэний оршин суух бүртгэл цахимжлаа” мэдээллийн өдөрлөг 2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 130 гаруй иргэдэд шилжин ирсний бүртгэл хийлгэхэд шаардлагатай баримт бичгийн бүрдэл, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/701 дугаар тушаалаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсон Хатгал тосгоны улсын бүртгэгч М. Даваахүүг 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 3 дугаар сарын 14-ний өдрийн хооронд, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Б/140 тушаалаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсон Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөнг 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 5 дугаар сарын 13-ны өдрийг дуусталх хугацаанд хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт мэдүүлэг хүлээн авах, эрхийн улсын бүртгэлд бүртгэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем / EPRS/-д бүртгэл хөтлөх, гэрээ гэрчилгээ олгох чиглэлээр ажлын 5 хоногийн дадлагажуулах ажлын байрны сургалтанд хамруулж, сумандаа эрхийн улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай үнэт цаас, бүртгэлийн маягт дэвтрийг хүлээлгэн өгч ажилласан. Дээрх сумд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумынхаа иргэдэд хүргэх ажлыг хэвийн хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Хатгал тосгоны улсын бүртгэгч М. Даваахүү нийт газар өмчлөх эрхийн чиглэлээр 102, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн чиглэлээр 76 нийт 178 бүртгэл, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн нь газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 8, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн чиглэлээр 9 нийт 17 бүртгэлийг тус тус хийсэн байна. 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн нь Цагаан-Уул суманд ажиллаж нийт 12 бүртгэл хийсэн бөгөөд газар өмчлөх эрхийн гэрчилгээ 8 иргэнд, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ 4-г тус тус олгосон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх ажлын удирдамж”-ийн дагуу тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг дуусталх хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 200 хувийн хэргийг цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулган хувийн хэргийн үзлэгийг хийж гүйцэтгэсэн. Дээрх 200 хувийн хэргээс 185 хувийн хэрэгт тусгаарлах баримт байхгүй байсан ба үлдсэн 15 хувийн хэрэгт нь тусгаарлах баримт буюу дуусгавар болсон барьцааны гэрээ, барьцаалбар, барьцааны гэрээ дуусгавар болгох, лавлагаа зэрэг баримтууд байсныг хувийн хэрэг тус бүрээр ангилан дугаарлахад нийт 377 хуудас нотолгооны ач холбогдолгүй баримт байсан. Үзлэг дүн шинжилгээ хийсэн тухай илтгэх хуудсыг жагсаалтын хамт УБЕГ-ын ЭХЭУБГ-т хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2022.03.09-ний өдрийн 6/2010 дугаартай чиглэл, хяналтын улсын байцаагчийн 2022.03.02-ны 1500 дугаартай дүгнэлт, улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газрын 2022.04.07-ны өдрийн 7/2971 дугаартай чиглэлийн дагуу мэдээллийн санд зөрчилтэй 2184 хувийн хэргийг архивын эх нотлох баримттай тулган эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт орууллаа. Засвар өөрчлөлтийн тайланг 7 хоног бүр гаргаж, засвар өөрчлөлтийн жагсаалтын хамт хяналтын улсын байцаагчид өгч хянуулж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас барьцааны гэрээ, барьцааны гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээг цахимаар эрхийн улсын бүртгэлд бүртгэх ажлыг үе шаттай зохион байгуулж байгаа ба энэ ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-06 маягт, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлт/ипотек/-г улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-13 маягтын загварыг шинээр баталж ирүүлсэн. Банк болон ББСБ иргэн хуулийн этгээдтэй байгуулсан барьцааны гэрээ, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийг дээрх маягтын дагуу хамтран гаргасан хүсэлтийн хамт хүлээн авч эрхийн улсын бүртгэлд бүртгэх ажлыг 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны 4 банк /ХААН банк, Төрийн банк, Голомт банк, Хас банк/-нд мөн Банк бус санхүүгийн байгууллага /Онч-Энх ББСБ, Бэрс финанс ББСБ, Транскапитал ББСБ, БИД ББСБ, Нэт капитал ББСБ/ -уудад УБЕГ-ын ЭХЭУБГ-аас ирүүлсэн мэдэгдэл, ЭУБ-06, ЭУБ-13 маягтын загварыг тус тус хүргүүлэн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Тус хэлтэс нь дээрх маягтууд батлагдсанаас хойш ЭУБ-06 маягтаар нийт 1274 барьцааны гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн ба ЭУБ-13 маягтаар нийт 48 барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Тус хэлтэст 2022.05.16-2022.05.31-ний хооронд бүртгэгдсэн нийт барьцааны гэрээ /барьцаалбартай, барьцаалбаргүй нийт/, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн судалгаа, 2022.06.02-2022.06.17-ний хооронд бүртгэгдсэн нийт барьцааны гэрээ /барьцаалбартай, барьцаалбаргүй нийт/, барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн судалгааг тус тус гаргаж 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлээ.

2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 2022 онд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нь олгогдсон сумдын улсын бүртгэгч нарын сумдад бүртгэгдсэн бүртгэлийн судалгааг гаргаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Нэгдсэн архивын газраас 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ирүүлсэн дотоод албан бичгийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Хөвсгөл аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсээс хууль хяналтын байгууллагад олгосон иргэний улсын бүртгэлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа мэдээллийн судалгааг гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Хугацаатай үүрэг даалгавар”-ын дагуу тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс зөрүүтэй, хуулийн этгээдийг иргэн төлөвтэй, хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэсэн гэх мэт барьцаалагчийг мэдээлэл алдаатай 58 бүртгэлийн хувийн хэргийг татаж, цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулгаж, хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн зөрчлийг арилгаж, засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэлээ. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэгж талбарын дугаар ороогүй 1 бүртгэлийн нэгж талбарын дугаарыг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн хэмжээ ороогүй 1 бүртгэлийн хэмжээг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн үнэ ороогүй газар болон үл хөдлөх эд хөрөнгийн 13 бүртгэлийн хувийн хэргийг татаж, хувийн хэрэгт тусгагдсан үнийг тус тус улсын бүртгэлийн дугаарын арын мөрөнд бичиж хүргүүлэн ажиллалаа.

2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар E-Mongolia төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл системд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, хуулийн этгээдийн цахим гэрчилгээ болон шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах зэрэг 784 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Төрийн өмчийн тооллогыг хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/08 тоот тушаалын дагуу хөрөнгө тус бүрийг нэг бүрчлэн тоолж, тооллогын тайланг байгууллагын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлж, актлах болон дахин үнэлэх хөрөнгүүдийн жагсаалтыг танилцуулсан. Үүний дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн №002 дүгнэлтээр 9 нэр төрлийн 14 ширхэг 27 518 865.58 төгрөгийн үнэ бүхий 27 518 865.58 төгрөгийн элэгдэлтэй машин тоног төхөөрөмж, 11 нэр төрлийн 15 ширхэг 4 453 650.00 төгрөгийн үнэ бүхий 4 453 650.00 төгрөгийн элэгдэлтэй Тавилга эд хогшлыг ашиглалтын хугацааг сунгаж дахин үнэлэх, мөн цаашид ашиглахааргүй болсон анхны үнээ бүрэн нөхсөн элэгдэл нь дууссан 14 нэр төрлийн 21 ширхэг 20 203 443.36 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 3 ширхэг 520 000.00 төгрөгийн тавилга эд хогшлыг актлах саналыг УБЕГ газарт хүргүүлээд байна.

УБЕГын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-өдрийн 8/4645 албан бичгээр ирүүлсэн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх зөвлөмжийг мөрдөн ажиллаж албан томилолтын зардалгүйгээр зөвхөн шатахууны зардал гарган 14 суманд тоон гарын үсэг олгох ажил болон алслагдсан 3 сумын 284 иргэний монгол улсын энгийн гадаад паспортын захиалга авч 9 230 000 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн.

Хоршооны тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хоршооны шинэчилсэн бүртгэлийг улс орон даяар зохион байгуулсан. Тус хэлтсийн хүрээнд 2022 онд нийт 33 хоршоо шинэчилсэн бүртгэлд хамруулаад байна.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тус тус зааснаар хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэх ажилд 176 хуулийн этгээд бүртгүүлсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хариутай албан бичгийг тогтоосон хугацаанд холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны байдлаар шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг хүргүүлсэн байна.

2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД

Нэг. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал:

Тус хэлтэс нь 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймгийн Голомт банктай хамтран лавлагаа, шилжилт хөдөлгөөн, үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний бүртгэлийн үйлчилгээний хураамжийг 5 ширхэг пос машинаар хүлээн авч, иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг улам ойртуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас Гэрэгэ киоск 1 ширхэг, Гэрэгэ пос машин 3 ширхэгийг тус хэлтэст шийдвэрлэн өгч, улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний хураамжийг бусад аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс анх удаа Гэрэгэ пос машин болох цахим төлбөрийн хэрэгслээр хүлээн авч байна. Тайлант хугацаанд Гэрэгэ киоск болон пос машинаар 1639 үйлчилгээний 11.636.760 төгрөг, Голомт банкны пос машинаар 5.796.100 төгрөгийн үйлчилгээний хураамжийг тус тус хүлээн авсан байна.

“Монгол улсын Иргэний үнэмлэх гардуулах ёслол”-ыг 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Мөрөн суманд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан болон Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран амжилттай зохион байгуулж, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн сурлага хөдөлмөр, урлаг, спортоор тэргүүлсэн 30 хүүхэд, мөн 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр тус аймгийн Засаг даргын тамгын газар, ГБХЗХГ-тай хамтран Мөрөн суманд амжилттай зохион байгуулж, Хөвсгөл аймгийн 16 хүүхэд иргэний үнэмлэхээ хүндэтгэлтэйгээр гардан авч, эх орон ард түмнийхээ өмнө тангараг өргөсөн.

Тус хэлтэс нь аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, ГХБХБГазар, ШШГГазар, ИХАШШ, ЗХАШШ, Прокурорын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Нийгмийн даатгалын хэлтэс, ХХҮГазар, тойргийн нотариатууд, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сумдын тамгын газрын дарга нар болон бусад байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна.

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь аймгийн Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тайлан мэдээг сар бүр хүргүүлж, 2017-2022 оны эхний хагас жилийн хоорондох зөрчлийн хэргүүдийн материалыг шалгуулан ажилласан.

2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ГХБХБГ-аас газрын харилцааны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцож иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаарх зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажилласан.

2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Монголын хуульчдын холбоо, Аймгийн ЗДТГ-ын санаачлан зохион байгуулсан “Хуульчийн Поро-боно өдөр-2022” иргэдэд хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх өдөрлөгт оролцож иргэдийг мэдээ мэдээллээр ханган зөвлөгөө өгч оролцсон.

2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн нээлт “ХӨДӨЛМӨРЧ ХӨВСГӨЛЧҮҮД” төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.

2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль-Эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Төрийн байгууллага”-уудын нээлттэй хаалганы өдөрлөгт тус хэлтэс нь оролцож иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч иргэдэд үйлчилсэн.

Мөрөн сумын ЗДТГазар, ИТХуралтай хамтран Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол оролцож, тус хэлтсийн эцэг эхийн зөвлөл Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газартай хамтран хүүхдийн эрх, аюулгүй байдал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим орчинд мэдээ мэдээллийг түгээн ажиллаж байна.

Мөн Мөрөн сумын Засаг даргын тамгын газраас зарласан “Хуулиа мөрдье -Иргэдээ сонсьё” аяны хүрээнд Мөрөн сумын 14 багийн иргэдэд шинээр гарсан хууль тогтоомж, шинэлэг үйлчилгээ хийгдэж байгаа ажлынхаа талаар танилцуулж хамтран ажиллав.

Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан Хөвсгөл аймаг дахь төрийн захиргааны байгууллагуудын дундах “Үйлчилгээгээ хялбаршуулъя” аянд нэгдэж 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 11-ний хооронд тодорхой арга хэмжээг зохион байгуулан тайланг хүргүүлсэн.

Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран шинээр төрсөн 2145 хүүхдэд дундын мэдээллийн сангаар дамжуулан регистрийн дугаарыг олгож, газар эзэмших эрхийн 2865 дугаар олгож, бүртгэлийн дугаар олгосон хуудсыг хэвлэн авч архивын нэгж үүсгэн хадгалж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгч аймгийн Татварын хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Статистикийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж шинээр бүртгэгдсэн болон татан буугдсан аж ахуй нэгжүүд, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа зэргийг улирал тутам тулган баталгаажуулан ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын хуралдаанд иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах улсын бүртгэлийн үйлчилгээний 2 киоск машин авах асуудлыг дэвшүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 53.600.000 төгрөгөөр 2 киоск машин шийдвэрлүүлсэн. Уг киоск машиныг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн иргэд иргэний улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй, тоон гарын үсгийг киоск машинаас авах боломж бүрдээд байна. Нэг киоск машиныг Шинэ Мөрөн худалдааны төвд байршуулж иргэдэд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ойртуулан ажиллаж эхлээд байна. Тус хугацаанд 238 иргэн лавлагаа авч, 51 иргэн тоон гарын үсгээ киоск машинаас авсан байна.

Хөвсгөл аймаг дахь Хүүхэд гэр бүл залуучууд, хөгжлийн газартай хамтран хэлтсийн 1 өрөөг гэр бүл залууст зориулан тохижуулахаар болсон бөгөөд өрөөний хэмжээг авч тохижуулах дизайн зураг төсвөө гаргасан байна. Өрөөний ханыг тохижуулах зургаа гаргаж мөн гэр бүл залууст мэдээлэл өгөх булан, жижиг ширээ тавиур байрлуулахаар төлөвлөсөн.

Хөвсгөл Аймгийн цэргийн штабтай хамтран аймгийн хэмжээнд 2022 оны намрын ээлжит цэрэг татлагад хамрагдаж байгаа Алаг-Эрдэнэ, Хатгал, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Их-уул, Рашаант, Ханх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Мөрөн сумдын засаг даргын тамгын газартай хамтран цэргийн насны бүх иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг амжилттай зохион байгуулан ажиллалаа.

Мөн хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар тухайн сумынхаа ЗДТГазартай хамтран тоон гарын үсэг олгох ажлын төлөвлөгөө гарган нийт төрийн албан хаагчид болон иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн мэдээлэл өгөх тоон гарын үсэг олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээнд **24372** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тус хэлтэст хамаарах 6 заалтыг хяналтандаа авч хэрэгжилтийг 100 хувь ханган, тайланг хугацаанд нь Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Ерөнхий сайдын санаачлагаар орон даяар хэрэгжсэн “Илүүдэлгүй жингүй-Эртэч Монгол” аянд хэлтсийн хамт олон нэгдэж 7 хоног бүрийн Лхагва гарагт идэвхитэй дасгал хөдөлгөөнд хамрагдан хэлтсийн нярав, бичиг хэргийн ажилтан Б.Маналжав илүүдэл жингээсээ хасан эртэч Монгол иргэн болж “Батламж”, мөнгөн шагнал гардан авсан.

Төрийн албаны ерөнхий шалгалт орон даяар 04 дүгээр сарын 01, 10 дугаар сарын 14-ны өдөр тус тус зохион байгуулагдаж тус хэлтэс аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран оролцогчдын хурууны хээний бүртгэлийг тулган ажиллаж, тоног төхөөрөмжийг хугацаанд нь аймгийн Тагнуулын байгууллагаар дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр аймгийн ЗДТГ замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан “Автомашингүй өдөр 10000 алхам” арга хэмжээнд хэлтсийн хамт олон оролцон, идэвхитэй хөдөлгөөн хийж эрүүл мэндээ дэмжлээ.

2022 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдөр Аймгийн боловсролын газартай хамтран Галт сумын ЕБСургууль, Жаргалант сумын ЕБСургуулийн багш албан хаагчдад үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн нийт 161 иргэнд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн ажилласан байна.

Бүтээлч ажил хийх ажлын хүрээнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран байгууллагын гадна талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн автомашины зогсоолын тэмдэглэгээ хийж байгууллагын гадаад орчин болон Мөрөн сумын орчны тохижилтыг хийхэд гар бие оролцон 80 ширхэг мод тарьж суулгасан.

Хоёр. Нэгжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд

Тус хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад ойлгомжтой байхаар үйлчилгээний зааланд самбар, хаалга, цонх тус бүрийн хаягийг шинэчлэн монгол бичигтэй хосолмол бичвэртэйгээр байрлуулсан. Үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил хийсэн. Тус хэлтсээр өдөрт дунджаар 140 гаруй иргэн сард 3000 гаруй иргэн үйлчлүүлдэг учир мэдээ мэдээлэл авч болохуйц, дулаан тав тухтай орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

Мөн эрх зүйн мэдээ мэдээллийн самбарыг шинээр хийлгэж байршуулсан бөгөөд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас бүтэн жилээр гарган холбогдох газар хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

Иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах, таниулах, сурталчлах цаг хугацаа хэмнэх зорилгоор бүртгэлийн үйлчилгээний төрөл тус бүрээр тайлбарласан мэдээллийн видео, баннарыг шинэчлэн бэлтгэж “Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” фэйсбүүк хуудас болон хэлтсийн цахим хаягаар “Түгээмэл асуулт хариулт” буланд 7 хоног бүр байршуулж хэвшсэн.

Иргэдэд тоон гарын үсэг олгох ажилтай холбогдуулан тоон гарын үсгийн давуу тал, хэрхэн юунд ашиглагдах талаар олны танил болон салбартаа манлайлагч болсон эрхмүүдийг оролцуулан 5 удаагийн видео шторк бэлтгэн мэдээллийн бүх хэрэгслээр сурталчлан ажиллаж байна.

Үйлчилгээгээ сайжруулах чиглэлээр гаргасан ажилтнуудын санал санаачлагыг дэмжиж иргэний андгай өргөх, гэр бүлийн андгай өргөх хүндэтгэлийн буланг тохижуулж эхэлсэн. Мөн мэдээллийн самбараа хэлтсийн албан хаагчид өөрсдийн нөөц бололцоог ашиглан шинэчлэн сайжруулж байршуулсан. Шинээр гэр бүл болж буй залуу хосууд болон 16 нас хүрсэн иргэний үнэмлэхээ гардан авч хүүхдүүдэд зориулан хүндэтгэлийн самбар хийж дурсгалын зураг татуулах боломжийг бүрдүүлсэн.

“E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн портал системээр дамжуулан улсын бүртгэлийн 56, үйлчилгээг хэрхэн авах талаар иргэдэд өдөр тутмын үйл ажиллагаагаараа дамжуулан сурталчлан ажиллаж, үйлчилгээний зааланд байрлуулсан цахим булангаар үйлчлүүлж буй 187 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, иргэдийн гар утсанд аппликейшн татаж өгч ажилласан. Мөн албан хаагчид өөрсдийн facebook хуудсаар “E-Mongolia” системтэй холбоотой 17 мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн өдрийн байдлаар хэлтсийн 16 хурал, даргын зөвлөлийн 18 хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэлтсийн албан хаагчдад тухай бүрт танилцуулан, биелэлтийг хуулийн хугацаанд нь УБЕГ-т хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудаст байршсан 75 болон фейсбүүк хуудсанд оруулсан 176 текстэн мэдээ болон видео мэдээ нийт 251 мэдээ, мэдээллийг мөн хэлтсийн хэмжээнд зохион байгуулсан ажлын 127 мэдээ мэдээллийг нийт 378 мэдээллийг хэлтсийн цахим хуудас болон фейсбүүк хуудсанд байршуулан сурталчлан ажилласан байна. Цахим хуудас болон фейсбүүк хуудсанд оруулсан мэдээллийг хэлтсийн нийт албан хаагчид болон сумдын улсын бүртгэгч нар иргэдэд тогтмол түгээн ажиллаж хэвшсэн.

Гурав. Идэвхи санаачлага, шинэлэг ажлын хүрээнд:

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраар Гэрэгэ киоск 1 ширхэг, Гэрэгэ пос машин 3 ширхэгийг шийдвэрлүүлэн авч, улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний хураамжийг бусад аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс анх удаа Гэрэгэ пос машин болох цахим төлбөрийн хэрэгслээр хүлээн авч байна. Тайлант хугацаанд Гэрэгэ киоск болон пос машинаар 1639 үйлчилгээний 11.636.760 төгрөгийг хүлээн авсан байна. Гэрэгэ пос, болон киоск машиныг үйлчилгээндээ нэвтрүүлснээр иргэдийн банк орох цаг завьг хэмнэн, үйлчилгээг улам ойртуулсан.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын хуралдаанд иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах улсын бүртгэлийн үйлчилгээний 2 киоск машин авах асуудлыг дэвшүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 53.600.000 төгрөгөөр 2 киоск машин шийдвэрлүүлсэн. Ингэснээр улсын бүртгэлийн байгууллагын орон нутгийн нэгжүүдээс анх удаа 2 киоск шийдвэрлүүлсэн аймаг боллоо. Уг киоск машиныг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн иргэд иргэний улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй, тоон гарын үсгийг киоск машинаас авах боломж бүрдээд байна. Нэг киоск машиныг Шинэ Мөрөн худалдааны төвд байршуулж иргэдэд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ойртуулан ажиллаж эхлээд байна. Тус хугацаанд 238 иргэн лавлагаа авч, 51 иргэн тоон гарын үсгээ киоск машинаас авсан байна.

Тус хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад ойлгомжтой байхаар үйлчилгээний зааланд самбар, хаалга, цонх тус бүрийн хаягийг шинэчлэн монгол бичигтэй хосолмол бичвэртэйгээр байрлуулсан. Үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил хийсэн ба иргэний баримтын архивт 1 ширхэг тавиур гагнуулж хийлгэсэн. Дээрх ажлын зардлыг багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас нийт 2 310 000 төгрөгөөр худалдан авалт хийсэн бөгөөд албан хаагчид дотоод нөөц бололцоогоо ашиглан өөрсдөө хийж гүйцэтгэсэн.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг шийдвэрлүүлэн авч, иргэдэд тоон гарын үсэг олгох ажилд ашиглаж байна.

Тус хэлтсээр өдөрт дунджаар 140 гаруй иргэн сард 3000 гаруй иргэн үйлчлүүлдэг учир мэдээ мэдээлэл авч болохуйц, дулаан тав тухтай орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

Үйлчилгээгээ сайжруулах чиглэлээр гаргасан ажилтнуудын санал санаачлагыг дэмжиж иргэний андгай өргөх, гэр бүлийн андгай өргөх хүндэтгэлийн буланг тохижуулж эхэлсэн. Мөн мэдээллийн самбараа хэлтсийн албан хаагчид өөрсдийн нөөц бололцоог ашиглан шинэчлэн сайжруулж байршуулсан. Шинээр гэр бүл болж буй залуу хосууд болон 16 нас хүрсэн иргэний үнэмлэхээ гардан авч хүүхдүүдэд зориулан хүндэтгэлийн самбар хийж дурсгалын зураг татуулах боломжийг бүрдүүлсэн.

Тус хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 онд шинээр иргэний үнэмлэх авах 2005, 2006 онд төрсөн 16 нас хүрч байгаа 2200 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг зэргийг шалгаж зөрчилтэй тохиолдолд архиваас ХААТР-11 маягтыг татаж зөрчлийг арилгуулахаар УБЕГ-т хүргүүлж ажилласан. Үүнээс: Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуагүй, ургийн овгийн мэдээлэл зөрүүтэй-84, эцэг/эх/-ийн нэр, нэр зөрсөн зөрчилтэй-46, мэдээллийн санд хаяггүй-25 иргэний мэдээллийг УБЕГ-т хүргүүлэн зөрчлийг арилгуулж цахим үнэмлэхийг баталгаажууллаа. Зөрчлийг урьдчилан шалгасны үр дүнд 16 нас хүрсэн иргэн үнэмлэхээ захиалахаар ирэхэд мэдээллийн санд зөрчилтэй шалтгаанаар хугацаа алдах эрсдэлгүй болж, иргэд хуулийн хугацаандаа үнэмлэхээ авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын тооллогын ажлыг 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхэлсэн ба 2022 оны 11 дүгээр 29-ний өдөр тооллого тулгалтын ажлыг бүрэн хийж дуусгалаа. Газар өмчлөх эрхийн 17654 хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 13098 тоолж нийт тооллогын ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив нь сэлбэн засах шаардлагатай хувийн хэрэг баримтыг нөхөн сэргээх, сэлбэн засах ажлыг өдөр тутмын үйл ажиллагаагаараа тогтмол хийж хэвшсэн ба архивын хувийн хэргийн цэнхэр хавстыг сольж шинээр цаасан бор хавтсанд хийж 30752 хувийн хэргийн хаягийг сольж байрлуулаад байна.

Айл өрхөд мэдээлэл түгээх, санал авах “Мэдээллийн богц”-ыг Галт сумын айл өрхүүдээр 2022 оны 03 сарын 30-ны өдрөөс аялуулж эхэлсэн. Галт баг буюу сумын төвийн багийн 127 өрхөд аялаж 300 гаруй иргэнд мэдээлэл түгээж 34 иргэн санал хүсэлт, 76 иргэн талархал ирүүлсэн байна. Мэдээллийн богцод Иргэний улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэлд хэрхэн бүртгүүлэх, ямар баримт бичиг бүрдүүлж ямар өргөдөл гаргах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ хэрхэн авах, газар өмчлөх эрхээ баталгаажуулах талаар болон гэрээний бүртгэлийн талаар гарын авлага мөн e-mongolia ашиглах бүртгэлийн лавлагаа авах, иргэний үнэмлэх гадаад паспорт захиалах, хоршооны шинэчилсэн бүртгэл, хоршоо нөхөрлөл байгуулах, тоон гарын үсгээ хэрхэн хаанаас авах болон түүний ач холбогдол хэрэглээний талаарх мэдээлэл ЗДТГ-ын цаг үеийн мэдээлэл, орон нутгийн хөгжлийн сангийн мэдээлэл шинээр батлагдсан хууль тогтоомж гэх мэт мэдээллийг багтаасан болно. 11 дүгээр сарын 30-ны байдлаар хөдөөгийн 4 багийн 400 гаруй өрхийн 1300 орчим иргэнд мэдээлэл түгээж иргэдийн санал хүсэлтийг авсан байна.

Тус хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч болон сумдын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS-2 системд нэвтрэх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-ын ЭХЭУБГ-т хүргүүлэн 25 албан хаагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS-2 системд нэвтрэх эрхийг нээлгэсэн байна.

Хэлтсийн байгууллагын архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэл хадгаламжийн нэгжүүдийг оноор, оны дотор хадгаламжийн нэгжүүдийг баримтын ач холбогдлоор нь дараалуулан байрлуулж, хадгаламжийн хугацаа дууссан баримт бичгийг устган ажилласан болно.

Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Монгол улсын хэмжээнд Цахим гарын үсгийн тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хэрэгжиж эхэлсэн. Уг хуульд зааснаар улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан. Уг хуулийн хэрэгжилтийг ханган Улсын бүртгэлийн ерөнхий газраас батлагдсан тоон гарын үсэг олгох төлөвлөгөөний дагуу хэлтсийн төлөвлөгөөг 7 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ой буюу чип, ухаалаг гар утасны аппликэйшнээр дамжуулан олгох ажлын бэлтгэл ажлыг ханган хэлтсийн дарга, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, мэдээлэл технологийн ажилтан болох 3 албан хаагч УБЕГ-с зохион байгуулсан “Сургагч багш бэлтгэх” сургалтад хамрагдсан. Мөн хэлтсийн 6 улсын бүртгэгч, сумын 23 улсын бүртгэгч, мэдээлэл технологийн 1 ажилтан нар УБЕГ-с зохион байгуулсан тоон гарын үсгийн тухай хууль болон програмын дадлага ажлын сургалтад тухай бүрт хамрагдан, тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг бүрэн ханган тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн ханган, тоон гарын үсэг олгох програмыг суулган өгч ажилласан.

Төлөвлөгөөний дагуу Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар тухайн сумынхаа ЗДТГазартай хамтран тоон гарын үсэг олгох ажлын төлөвлөгөө гарган нийт төрийн албан хаагчид болон иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулж, тоон гарын үсэг олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж 22 сумын хэмжээнд **18306**, аймгийн төв Мөрөн сумын **6066** иргэнд тоон гарын үсэг олгосон байна. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээнд **24372** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг 44 төрийн байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль, 15 цэцэрлэг нийт 67 аж ахуй нэгжийн **3428** албан хаагчдад тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсэг олгоход дотоод сүлжээний асуудлыг 4G төхөөрөмж ашиглан шийдсэн бөгөөд өөрсдийн биеэр хэлтэст ирж тоон гарын үсэг авах боломжгүй төрийн албан хаагчдын цаг завьг хэмнэсэн шинэлэг ажил болсон. Мөн худалдааны үйл ажиллагаа явуулдаг томоохон үйлчилгээний газрууд дээр сууж **185** иргэнд тоон гарын үсэг олгосон.

Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд Хөвсгөл Аймгийн цэргийн штабтай хамтран аймгийн хэмжээнд 2022 оны намрын ээлжит цэрэг татлагад хамрагдаж байгаа Алаг-Эрдэнэ, Хатгал, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Их-уул, Рашаант, Ханх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Мөрөн сумдын цэргийн насны бүх **948** иргэнд тоон гарын үсэг олгох ажлыг амжилттай зохион байгуулан ажиллалаа.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Тариалан, Тосонцэнгэл зэрэг 6 суманд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөр”-т **756** иргэнд тоон гарын үсэг олгосон.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг шийдвэрлүүлэн авч, 2022 оны 11 дүгээр сараас эхлэн Хаан банк тоон гарын үсгээр үйлчилгээ үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан төв Хаан банк болон хаан банкны захын салбараар үйлчлүүлж буй иргэдэд тоон гарын үсэг олгож байна. Одоогийн байдлаар **224** иргэнд тоон гарын үсгийг иргэний цахим үнэмлэх болон, утасны аппликейшнээр дамжуулан олгосон байна. Мөрөн сумын хэмжээнд олгосон **6066** тоон гарын үсгийн 91 хувийг өөрсдийн идэвхи санаачлагын хүрээнд очиж үйлчилсэн байх бөгөөд нийт **525** иргэн хэлтсийн улсын бүртгэгчээс тоон гарын үсэг авсан

Тоон гарын үсэг олгох ажлыг суманд эрчимжүүлэх ажлын хүрээнд сумын ЗДТГ-тай хамтран багийн өдөрлөг зохион байгуулах газруудад өгч ажиллуулах хуваарь гарсны дагуу дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг Рашаант суманд хүргүүлсэн болно.

Тав. Нээлттэй хаалганы өдөр

ОХУ-н хил 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр нээгдсэнтэй холбогдуулан хилийн боомт бүхий Ханх сумын ЗДТГазар, ИТХурлын хүсэлтийн дагуу Ханх суманд 2022 оны 3-р сарын 30-31 ний өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулан ажиллалаа. Тус өдөрлөгөөр Үндэсний энгийн гадаад паспортын хүчинтэй хугацаа дууссан, шинээр захиалж байгаа 134 иргэний гадаад паспортын захилага хүлээн авч холбогдох хууль журмын дагуу Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, иргэдийн цаг хугацаа, санхүү хэмнэж ажилласан байна. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 42 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 2 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 3 иргэнд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ тус тус олгосон.

2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ГХБХБГ-аас газрын харилцааны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцож иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Уг нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт 31 иргэнд үйлчилсэн байна.

2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Монголын хуульчдын холбоо, Аймгийн ЗДТГ-ын санаачлан зохион байгуулсан “Хуульчийн поро боно өдөр-2022” иргэдэд хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх өдөрлөгт оролцож иргэдийг мэдээ мэдээллээр ханган зөвлөгөө өгч оролцсон.

2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн нээлт “ХӨДӨЛМӨРЧ ХӨВСГӨЛЧҮҮД” төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон иргэдэд мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Хөвсгөл аймгийн хамгийн их хүн амтай Тариалан сумын засаг даргын тамгын газартай хамтран тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулан ажиллаж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 56 иргэнд, тоон гарын үсэг 148 иргэнд олгож ажилласан байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 51 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 7 иргэнд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон байна. Мөн барьцааны гэрээ-4, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл-1, худалдах худалдан авах гэрээ-1-ийг тус тус бүртгэсэн ба хувийн хэрэг хаах материал 4-ийг хүлээн авч УБЕГ-ын ЭХЭУБГ-т хүргүүлэн УБЕГ-ын даргын тушаал гарсны дагуу хувийн хэрэг бүртгэлийг хаасан байна.

2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Бүрэнтогтох суманд “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулсан бөгөөд 69 иргэнд тоон гарын үсэг олгон, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай хүргэж нийт 11 бүртгэл хөтөлж ажилласан.

2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль-Эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Төрийн байгууллага”-уудын нээлттэй хаалганы өдөрлөгт тус хэлтэс нь оролцож иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч иргэдэд үйлчилсэн бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 15 иргэний гэрчилгээг өдөрт нь багтаан олгосон байна.

2022 оны 06 дугаар сарын 23,24-ны өдрүүдэд Цахим хөгжлийн яамтай хамтран Их-Уул, Тариалан, Тосонцэнгэл сумдад “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулсан. Уг өдөрлөгөөр Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг давхардсан тоогоор 127 иргэнд үзүүлж 315 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж нийт 63 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, Тариалан суманд 2 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 3 иргэнд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон ба барьцааны гэрээ-3, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл-2г тус тус бүртгэсэн. Их-Уул суманд 3 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 1 иргэнд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ, Тосонцэнгэл суманд 2 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээг тус тус олгосон байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 14 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 2 улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон.

2022 оны 08 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд Цахим хөгжлийн яамтай хамтран зохион байгуулсан Тариалан сумын Таван толгой, Ар тархи багуудад зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрт оролцож 84 иргэнд тоон гарын олгож, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 28 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

2022 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдөр Аймгийн боловсролын газартай хамтран Галт сумын ЕБСургууль, Жаргалант сумын ЕБСургуулийн багш албан хаагчдад үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн иргэдэд “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж, нийт 161 иргэний үндэсний энгийн гадаад паспортын захиалга авч, 140 иргэнд тоон гарын үсэг олгосон

Зургаа. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2022 оны 1-р улиралд албан хаагчдын хувцсыг жигдрүүлэх арга хэмжээний хүрээнд хувцасны үнэ, загвар, өнгөний судалгаа хийж ажилласан боловч УБЕГын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-өдрийн 8/4645 албан бичгээр ирүүлсэн төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд уг ажил хойшилсон байна.

Төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдыг 7 хоног бүр халуун аарц, чацаргана, аньсаар дархлааг нь дэмжин коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2022.04.29-ний өдрийн 1/3742 тоот албан бичгийн дагуу Улаанбаатар хотод урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзлэгт хамрагдах албан хаагчдын судалгааг гарган хүргүүлсэн.

Тус хэлтсийн өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Хатгал тосгоны улсын бүртгэгч М.Даваахүүгийн ар гэрт дэмжлэг үзүүлэх саналыг УБЕГ-т хүргүүлж, 5.000.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон байна.

Тус хэлтсийн Арбулаг, Цагаан-Уул, Цагааннуур, Чандмань-Өндөр, Их-Уул сумдын ЗДТГ-аас тус хэлтсийн улсын бүртгэгч нарыг УБ хотод эрүүл мэндийн багц үзлэгт хамруулж, хамтран ажиллах талаар ирүүлсэн албан бичгийн дагуу хэлтсийн зүгээс дээрх 5 сумын улсын бүртгэгч нарт 3 хоногийн чөлөөг олгон, үзлэг оношилгоонд хамруулсан.

Мөн Алаг-Эрдэнэ, Галт, Их-Уул, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумдын улсын бүртгэгч нарын гаргасан Глобал их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцан танхимаар хилээллэх 14 хоногийн чөлөөний хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэн УБЕГ-н даргын тушаал гарж, чөлөөг олгосон хугацаанд бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлсэн. Мөн хэлтсийн даргын 45 чөлөөний хуудсаар албан хаагчдад чөлөө олгож ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн ажилтан А.Лхагвасүрэнгийн охин болон Хан-Уул дүүргийн улсын бүртгэгчийн гэр бүлийн хүний эмчилгээний зардалд хандив өргөж, сайн үйлсийн аянд хамт олноороо нэгдсэн.

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр аймгийн ЗДТГ замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан “Автомашингүй өдөр 10000 алхам” арга хэмжээнд хэлтсийн хамт олон оролцон, идэвхитэй хөдөлгөөн хийж эрүүл мэндээ дэмжлээ. 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Оюуны дасгалжуулагч багш Дэнсмаа, Нямханд нарын “Хувь хүний хөгжил буюу super jump” сэдэвт сургалтад хамрагдаж, гоо зүйн талаарх мэдлэгээ дээшлүүлсэн.

2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн санаачлагаар зохион байгуулсан төрийн албан хаагчдын эрүүл мэндийн оношлогооны ясны сийрэгжилтийн шинжилгээнд хэлтсийн 13 албан хаагч хамрагдаж, тохирох эмчилгээний зөвлөгөөг авсан.

2022 оны 11 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд хэлтсийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор албан хаагчдын дунд спортын арга хэмжээ зохион байгуулж, урамшуулан ажиллалаа.

Тус хэлтсийн үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил зохион байгуулж, хэлтсийн албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулсан.

Мөн улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний түүхт 82 жилийн ойн хүрээнд ажил албан үүргээрээ бусад албан хаагчдаа манлайлсан 1 албан хаагчийг Хууль зүйн яамны Хүндэт жуух бичиг, 2 албан хаагчийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Жуух бичиг, 8 албан хаагчийг Хөвсгөл аймгийн ЗДТГ, ИТХ-ын хурлын шагналаар шагнаж урамшууллаа.

3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Үндсэн хууль, Улсын Бүртгэлийн ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллалаа. Бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 11 дүгээр сарын 25 ны байдлаар төрсний бүртгэл 2145 үүнээс эрэгтэй 1101, эмэгтэй 1044, гэрлэсний бүртгэл 430 үүнээс анхны гэрлэлт 367, дахин гэрлэлт 63 гэрлэлт сэргээсний бүртгэл 0, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 130, үүнээс захиргааны журмаар 29, шүүхийн журмаар 101, үрчилсний бүртгэл 55, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 128, ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 105, нас барсны бүртгэл 833 тус тус бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 21, шүүхийн шийдвэрээр 2 иргэний регистрийн дугаарыг өөрчилж, иргэнийн улсын бүртгэлийн мэдээллийн төрсний бүртгэлд эцэг болон эхийн мэдээлэл нь бүртгэгдээгүй 66 иргэний бүртгэлийг иргэний баримтын архиваас хуулбарлан Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчил арилгаж ажилласан байна.

1988, 1989, 2008 онд төрсөн иргэдийн иргэний улсын бүртгэлийн мэдээлийн санд алдаатай төлөвтэй байгаа 25 иргэний бүртгэлийн зөрчлийг ИУБГазарт хүргүүлж зөрчил арилгасан.

Гэрлэлтийн бүртгэл нь мэдээллийн санд бүртгэлгүй 30 иргэний бүртгэлийг нягтлан шалгаж мэдээллийн санд оруулсан.

Мөн 2004, 2005, 2006 онд төрсөн хүүхдийн ургийн овгийг иргэний улсын бүртгэлийн нэрийн санд тусгуулахаар УБЕГ-ын ИУБГазарт 116 иргэний бүртгэлийг жагсаалтаар хүргүүлэн зөрчлийг арилгасан.

Иргэний улсын бүртгэлийн нэрийн санд гэрлэлтийн төлөв өөрчлөх 64 иргэний хүсэлтийг жагсаалтаар хүргүүлэн зөрчлийг залруулсан.

Иргэний улсын бүртгэлийн /ИУБ/ маягтуудыг үсгийн дарааллар галиглан УБЕГ-ын нэгдсэн архивт /А/ талыг, /Б/ талыг иргэний баримтын архивт жагсаалтын хамт хүлээлгэн өгсөн.

Хоёр. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 638 бүртгэл үүнээс насанд хүрсэн 394, хүүхэд /16-аас доош насны/ 244, сум хооронд шилжин ирсэн 1342 бүртгэл үүнээс насанд хүрсэн 725, хүүхэд /16-аас доош насны/ 569, баг хооронд шилжин ирсэн 1734 бүртгэл үүнээс насанд хүрсэн 916, хүүхэд /16-аас доош насны/ 818 нийт 3715 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Албан тоотоор ирүүлсэн нийслэл болон бусад аймгийн нийт 1000 иргэний материалыг хүргүүлж ажилласан. Албан тоотоор нийслэл болон аймгаас ирсэн нийт 400 иргэний хувийн хэрэг материалыг авч архивт өгч баяжилт хийсэн байна.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран хаягийн зөрчилтэй хүүхдийн мөнгө нь ороогүй 143 хүүхдийн судалгааг гаргаж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчил арилган ажиллаж байна.

Галт, Тариалан, Түнэл сумын ИТХурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны 4-р сарын 19 ний өдрийн А/284 тулаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажиллаж, сонгуулийн дараа өдөрөөс шилжилт хөдөлгөөний бүртгэлийг нээж сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

“Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага”, “Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” ТББ-тай хамтран “Иргэний оршин суух бүртгэл цахимжлаа” мэдээллийн өдөрлөг 2022 оны 9 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 130 гаруй иргэдэд шилжин ирсний бүртгэл хийлгэхэд шаардлагатай баримт бичгийн бүрдэл, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Гурав.Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 6607 бүртгэл үүнээс шинэ 1957, хаяж үрэгдүүлсэн 1450, хорин таван насны сунгалт хийлгэсэн 1534, дөчин таван насны сунгалт 1659 бүртгэл хийгдэж 5155 иргэний цахим үнэмлэхний зураг засч сүлжээнд оруулан хэвлүүлсэн байна.

Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуулахгүй, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр зөрүүтэй 84 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчил арилгаж иргэний цахим үнэмлэх хэвлүүлэн ажилласан байна.

Шинээр иргэний үнэмлэх авах насанд хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насад хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, иргэний улсын бүртгэлийн газраас иргэний үнэмлэхийн бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдөл ИУБ31 бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэлийг цаг тухай бүрт сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хурууны хээ давхардсан, зөрсөн 46, нэрийн толинд нэр баталгаажуулаагүй, ургийн овог, эцгийн нэр, нэр зөрсөн зөрчилтэй зэрэг 25 иргэний мэдээллийг УБЕГ хүргүүлэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн байна. ИУБ-31 маягтын А талыг УБЕГ-ын иргэний улсын бүртгэлийн газарт, Б талыг архивт мөн 5155ш ИУБ-31 маягыг УБЕГ-ын иргэний баримтын архивт хүргүүлсэн.

Тус хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 онд шинээр иргэний үнэмлэх авах 2005, 2006 онд төрсөн 16 нас хүрч байгаа 2200 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг зэргийг шалгаж зөрчилтэй тохиолдолд архиваас ХААТР-11 маягыг татаж зөрчлийг арилгуулахаар УБЕГ-т хүргүүлж ажилласан. Үүнээс: Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуулаагүй, ургийн овгийн мэдээлэл зөрүүтэй-84, эцэг/эх/-ийн нэр, нэр зөрсөн зөрчилтэй-46, мэдээллийн санд хаяггүй-25 иргэний мэдээллийг УБЕГ-т хүргүүлэн зөрчлийг арилгуулж цахим үнэмлэхийг баталгаажууллаа. Зөрчлийг урьдчилан шалгасны үр дүнд 16 нас хүрсэн иргэн үнэмлэхээ захиалахаар ирэхэд мэдээллийн санд зөрчилтэй шалтгаанаар хугацаа алдах эрсдэлгүй болж, иргэд хуулийн хугацаандаа үнэмлэхээ авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

16 нас хүрч анх удаа иргэний үнэмлэхээ захиалсан Мөрөн сумын ЕБС-ийн сурагчдын нийт 66 хүүхдийн дунд аймгийн Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран иргэний андгай өргөх үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн БШУ-ны сайд Л.Энх-Амгалан, аймгийн БШУГазрын дарга Ц.Ганзориг нар сурагчдад эх оронч үзэл төлөвшүүлэх зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. УБХэлтсээс сурагчдад иргэний үнэмлэх түүний ач холбогдол цаашид анхаарвал зохих зүйлийн талаар мэдээлэл өгч, иргэний андгайг өргүүлж, иргэний үнэмлэх, гарын бэлэг гардуулсан.

“Титэм ЕБС”-ийн 9-12 дугаар ангийн нийт 128 хүүхдэд иргэний үнэмлэхийн ач холбогдол, цаашид анхаарах зүйлийн талаар мэдээлэл бэлтгэн хүргэж гарын авлага тарааж ажилласан.

Дөрөв. Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:

Үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажлын хүрээнд нийт шинээр 2124 иргэний гадаад паспортын захиалга авч УБЕГазарт хүргүүлсэн бөгөөд хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтын бүртгэл 718 бүртгэгдсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 1/8275 тоот “Гадаад паспортын хөтлөх тухай” чиглэлийн дагуу үндэсний энгийн гадаад паспортын үйлдвэр ашиглалтад орсонтой холбогдуулан 10 дугаар сарын 01-ний өдрөөс олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын /ИКАО/-ын стандарт шаардлагын дагуу гадаад паспорт захиалж байгаа иргэдийн цээж зургийг хэлтэст авах нөхцөл техник тоног төхөөрөмжийг бэлтгэн тусдаа өрөөг тохижуулан гадаад паспортын захиалгыг хүлээн авч байна.

Сумдын улсын бүртгэгч нарт гадаад паспорт захиалах буюу зураг авах стандарт болон зураг засах программ дээр ажиллах заавар зөвөлгөө өгч, дадлагажуулан ажиллалаа.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж УБЕГ-с Үндэсний энгийн гадаад паспорт, Иргэний цахим үнэмлэх хэвлэгдэн ирсэн тухай мэдээллийг түргэн шуурхай хүргэж “Иргэн ... Таны Цахим үнэмлэх /Үндэсний энгийн гадаад паспорт/ хэвлэгдэн ирсэн байна” гэсэн мессеж явуулж хэвсхсэн байна.

Ханх сумын ЗДТГазар, ИТХурлын хүсэлтийн дагуу Ханх суманд 2022 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулан ажиллалаа. Тус өдөрлөгөөр Үндэсний энгийн гадаад паспортын хүчинтэй хугацаа дууссан, шинээр захиалж байгаа 134 иргэний гадаад паспортын захиалга хүлээн авч холбогдох хууль журмын дагуу Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, иргэдийн цаг хугацаа, санхүүг хэмнэж ажилласан байна.

Мөн 2022 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдөр Аймгийн боловсролын газартай хамтран Галт сумын ЕБСургууль, Жаргалант сумын ЕБСургуулийн багш албан хаагчдад үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн нийт 161 иргэнд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн ажилласан байна.

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд:

Галт, Тариалан, Түнэл сумын ИТХурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/284 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажиллаж байна. Нөхөн сонгууль бүхий сумдын сонгогчдын нэрийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох хууль, журмын хүрээнд нятлан шалгаж 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хэвлэж, тухай сумдын сонгуулийн хороонд хуулийн хугацаанд хүлээлгэн өгч ажиллалаа.

Нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд сонгуулийн өдөр итгэмжлэгдсэн ажилтны ажиллах ирц бүртгэлийн программ бүхий тоног төхөөрөмжийн иж бүрдэлийг 2022 оны 06 дугаар сарын 2-4-ний хооронд УБЕГазраас цагдаа, тагнуулын хамгаалалттайгаар хүлээн авч Хөвсгөл аймаг дахь тагнуулын хэлтэст хадгалсан. Сонгуулийн СНЖагсаалт хэвлэгдэн сумын сонгуулийн хэсгийн хороонд хүлээлгэн өгснөөс хойш СНЖагсаалтад өөрчлөлт оруулах лавлагаа хэвлэх ажлыг хийж гүйцэтгэж 2022 оны 06 дугаар сарын 09-ний байдлаар Галт сумын Нүхт багийн нас барсан 1 иргэний лавлагаа хэвлэсэн.

2022 оны 6 дугаар сарын 19-ний өдөр нөхөн сонгууль бүхий Галт, Тариалан, Түнэл сумын улсын бүртгэгч нар итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллаж хуульд заасны дагуу ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллалаа. Тус хэлтсийн шуурхай багийн бүрэлдэхүүн итгэмжлэгдсэн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, 11, 16, 20 цагийн мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж УБЕГазрын БТДШГазарт хүргүүлсэн ба Галт сум 51,17%, Тариалан сум 74%, Түнэл сум 41,47%-ийн ирцтэй санал хураалт явагдаж Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна. Сонгууль зохион байгуулагдсан 3 сумын ирц бүртгэлийн программ бүхий тоног төхөөрөмжийн иж бүрдлийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр татан авч УБЕГазарт хүлээлгэн өгсөн байна.

Зургаа. Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагаа, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн "нээлттэй" мэдээллийг иргэдэд 10956, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 668, албан хэрэгцээнд 3265 лавлагааг олгож иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 9630 ИУБ маягтуудын баяжилт хийж хураасан бөгөөд үүнд төрсний бүртгэл /ИУБ-11/ 2145, үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 52, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 105, эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 119, гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 430, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 130, нас барсны бүртгэл /ИУБ-18/ 833, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /ИУБ-31/ 5155, шилжин ирсэн 638, бусад аймаг хотод бүртгэл хийлгэсэн 619 маягт иргэний баримтын архивт баяжилт хийсэн байна.

Хэлтсийн архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган иргэний баримтын архивын чиглэлээр 4, эд хөрөнгийн баримтын архивын чиглэлээр 3, хуулийн этгээдийн баримтын архивын чиглэлээр 2, нийт 9 арга хэмжээг тусган хэрэгжилтийг бүрэн гүйцэт ханган ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5-д заасны дагуу Иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 24 сумын улсын бүртгэгчээс татан авч хадгаламжийн нэгж 2021 оны бүртгэлийн 325 дэвтэр болон бүрдүүлбэрийг хадгалалтын стандартын шаардлагын дагуу хүлээн авч архивт баяжилт хийсэн байна.

Бусад аймаг, хотод бүртгэл хийлгэсэн 619 иргэний холбогдох маягтыг тус бүр хувийн хэрэгт хавсаргасан. Мөн түүнчлэн бусад аймаг хотоос албан бичгийн дагуу ирсэн 83 иргэний холбогдох ХААТР, ИУБ маягтуудыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулсан.

Хяналтын улсын байцаагч болон тасгийн дарга, улсын бүртгэгчдэд архиваас түр ашиглахаар 98 иргэний хувийн хэргийг авахаар захиалсан бөгөөд хүлээлгэн өгч буцаан авсан байна.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний болон эцэг, эхийн мэдээлэл зөрсөн болон зөрчилтэй 86 иргэний ХААТР, ИУБ маягт, холбогдох бүртгэлийн дэвтрийн хуулбарыг мөн тухайн бүртгэлтэй холбоотой дэвтэр шүүж зөрчил арилгуулахаар улсын бүртгэгч Б.Дуламсүрэнд хүлээлгэн өгч зөрчил арилган ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/804 тоот чиглэлийн дагуу 272 иргэний ХААТР, ИУБ маягтуудын Б талыг цахимжуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн нэгсэн архивын газарт 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр албан бичиг хүргүүлэн сумын улсын бүртгэгч нарт цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программд харах эрх нээлгэж онлайн сургалт хийж мэдээ мэдээлэл өгч ажилласан байна.

Өмнө оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэний баримтын архивт хадгалагдах хүүхдийн сан, нас баралтын санг 100% тоолж дууссан. Энэ оны төлөвлөгөөнд хувийн хэргийн санг тоолж дуусгахаар тусгасан бөгөөд үндсэн хувийн хэргийн тооллогыг 100% хийж гүйцэтгэлээ. Иргэний баримтын архив нь 100% дүүргэлттэй хувийн хэрэг тавих тавиургүй тооллогын ажил түр зогссон байсныг хадгаламжийн нэгжийн архив тусдаа №101 өрөөнд нүүж орсноор иргэний баримтын архивт хувийн хэргийн 2 тавиур тавих зай гарсан байсныг өнөөдрийн байдлаар 60см3м2м бүхий 1 тавиур хийж байршуулсан болно. Хадгаламжийн нэгжийн архив тусдаа өрөөнд байршуулсанаар 6м60см2м 1 тавиур байрлуулж хадгаламжийн нэгж тус бүрээр ангилан байршуулсан.

ББНШК-ын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийн дагуу хадгалах хугацаа нь дууссан ИУБ21 9250 \баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт 30\ архиваас түр олгох бүртгэлийн дэвтэр “МАЯГТ А2” \хадгалах хугацааны жагсаалтын-47\, эд хөрөнгө бүтгэлтэй эсэх, барьцаатай эсэх лавлагаа \ хадгалах хугацааны жагсаалтын-48\, захиалгын хуудас \ хадгалах хугацааны жагсаалтын-49\ нэр төрлийн баримтыг комиссын гишүүд Мөрөн сумын 1-р багт байрлах Ирээдүй сургуулийн уурын зууханд шатааж устгасан.

УБЕГ-ын 10-р сарын 12-ны өдрийн 10/8626 тоот албан бичгийн дагуу 2023 онд хадгалах хугацаа нь дууссан бүртгэлийн дэвтэр, бүртдүүлбэр, ИУБ21, ИУБ22 маягтыг устгах саналд хүргүүлээ.

Долоо. Цахим гарын үсэг олгох ажлын хүрээнд:




Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ой буюу чип, ухаалаг гар утасны аппликэйшнээр дамжуулан олгох ажлын бэлтгэл ажлыг ханган хэлтсийн дарга, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, мэдээлэл технологийн ажилтан болох 3 албан хаагч УБЕГ-с зохион байгуулсан “Сургагч багш бэлтгэх” сургалтад хамрагдсан. Мөн хэлтсийн 6 улсын бүртгэгч, сумын 23 улсын бүртгэгч, мэдээлэл технологийн 1 ажилтан нар УБЕГ-с зохион байгуулсан тоон гарын үсгийн тухай хууль болон программын дадлага ажлын сургалтад тухай бүрт хамрагдан, тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг бүрэн ханган тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн ханган, тоон гарын үсэг олгох програмыг суулган өгч ажилласан.

Төлөвлөгөөний дагуу Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар тухайн сумынхаа ЗДТГазартай хамтран тоон гарын үсэг олгох ажлын төлөвлөгөө гарган нийт төрийн албан хаагчид болон иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулж, тоон гарын үсэг олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж 23 сумын хэмжээнд **18306** иргэнд тоон гарын үсэг олгосон байна. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээнд **24372** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг 44 төрийн байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль, 15 цэцэрлэг нийт 67 аж ахуй нэгжийн **3428** албан хаагчдад тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсэг олгоход дотоод сүлжээний асуудлыг 4G төхөөрөмж ашиглан шийдсэн бөгөөд өөрсдийн биеэр хэлтэст ирж тоон гарын үсэг авах боломжгүй төрийн албан хаагчдын цаг завьг хэмнэсэн шинэлэг ажил болсон. Мөн худалдааны үйл ажиллагаа явуулдаг томоохон үйлчилгээний газрууд дээр сууж **185** иргэнд тоон гарын үсэг олгосон. Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг шийдвэрлүүлэн авч, 2022 оны 11 дүгээр сараас эхлэн Хаан банк тоон гарын үсгээр үйлчилгээ үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан төв Хаан банк болон хаан банкны захын салбараар үйлчлүүлж буй иргэдэд тоон гарын үсэг олгож байна. Одоогийн байдлаар **224** иргэнд тоон гарын үсгийг иргэний цахим үнэмлэх болон, утасны аппликэйшнээр дамжуулан олгосон байна. Мөрөн сумын хэмжээнд олгосон **6066** тоон гарын үсгийн 91 хувийг өөрсдийн идэвхи санаачлагын хүрээнд очиж үйлчилсэн байх бөгөөд нийт 525 иргэн хэлтсийн улсын бүртгэгчээс тоон гарын үсэг авсан

Тоон гарын үсэг олгох ажлыг суманд эрчимжүүлэх ажлын хүрээнд сумын ЗДТГ-тай хамтран багийн өдөрлөг зохион байгуулах газруудад өгч ажиллуулах хуваарь гарсны дагуу дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг Рашаант суманд хүргүүлсэн болно.

Найм. Иргэний улсын бүртгэлийн сүүлийн 3 жилийн судалгааг графикаар харуулав:



4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Улсын тэмдэгтийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын засгийн газрын 2020.12.23-ны өдрийн 230 дугаар тогтоол, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулж иргэнийг эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх бүрэн боломжоор хангах зорилт тавин ажиллаж нийт **10338** мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан байна.

Иргэдээс “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д заасан шалтгаанаар хувийн хэрэг хаалгахаар ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичиг, мэдүүлгийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 36, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 6 хувийн хэрэг бүртгэлийг улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар тус тус хаасан байна. Мөн иргэн хуулийн этгээдээс үрэгдүүлсэн гэрчилгээг дахин авах тухай өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцуулж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 27, газар өмчлөх эрхийн 20 гэрчилгээг дахин олгож ажиллалаа.

Тайлант хугацаанд бүртгэсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг төрөл тус бүрээр ангилан авч үзвэл:

Нэг. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх

Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт **485**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 800-г бүртгэж нийт **1285** шинэ хувийн хэрэг үүсгэн архивт байрлуулснаар хувийн хэргийн нийт тоо **30752** болсон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүлээн авсан мэдүүлгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:




Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:




Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



2022 онд сумдаас бүртгэгдсэн газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн тоог харьцуулбал




2022 онд сумдаас бүртгэгдсэн газар өмчлөх эрхийн бүртгэлийн тоог харьцуулбал




Хоёр. Барьцааны бүртгэл /ипотек/

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн барьцааны бүртгэлийн **4466** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцаалбартай барьцааны гэрээ **1268**, барьцаалбаргүй барьцааны гэрээ **1214**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **77**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1907**-г тус тус хүлээн авч бүртгэсэн. Мөн газар өмчлөх эрхийн барьцааны бүртгэлийн **2672** мэдүүлэг хүлээн авсан ба үүнээс барьцаалбаргүй барьцааны гэрээ **1444**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **16**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1212**-ийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна.




Гурав. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх

2022 онд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл **805**, газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэл **657** нийт **1462** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр **133**, ХХАГ-ээр **1049**, арилжааны гэрээгээр **2**, өв залгамжлах эрхийн бүртгэл **160**, хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр **106**, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх **4**, бусад гэрээ хэлцлээр **8** бүртгэл тус тус бүртгэсэн байна.




Дөрөв. Эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах **398** мэдүүлэг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн байна. Үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох-**47**, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох-**4**, өмчлөгчийн овог нэр регистрийн дугаар өөрчлөгдөх-**19**, эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх-**166**, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх-**20**, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх-**128**, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх-**3**, эд хөрөнгийн үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх-**11** тус тус бүртгэж, холбогдох материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа.



Тав. Лавлагаа хуулбар олголт:

Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт **1051** лавлагаа, хуулбар **8** тус тус олгосон байна. 2022 онд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа олголтын бүртгэл эрс ихэссэн нь 2022.05.01-ний өдрөөс эхлэн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Хур систем”, “ТҮЦ” машинаас хурууны хээгээр лавлагаа мэдээллээ авч болохгүй болсонтой холбоотой юм.



Зургаа. Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:

Аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумын газрын даамлын газар эзэмших ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр дундын мэдээллийн санд оруулж эзэмших эрхийн дугаар авсан **2865** бүртгэлийн дугаар олгосон хуудсыг хэвлэн авч архивын нэгж үүсгэн хадгалж байна.

Долоо . Архив, мэдээллийн сан, үйлчилгээний хураамжийн талаар:


2022 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөө болон архивын тооллогын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивт газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 17654, газар өмчлөх эрхийн 13098, нийт 30752 хувийн хэрэг хадгалагдаж байна. 2022 онд газар өмчлөх эрхийн нийт 485, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 800 нийт 1285 хувийн хэрэг шинээр нэмэгдсэнийг архивт байрлууллаа.

Архивын тооллого, тулгалтын ажлыг төлөвлөгөөний дагуу 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэн хэрэгжүүлэн ажилласан ба 2022 оны 11 дүгээрр 29-ний өдөр тооллого тулгалтын ажлыг бүрэн хийж дуусгалаа. Газар өмчлөх эрхийн 17654 хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 13098 тоолж нийт тооллогын ажлыг амжилттай хэрэгжүүллээ.

Тооллого тулгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ нэг улсын бүртгэгч өдөрт 100 хувийн хэрэг, улсын ахлах бүртгэгч 200 хувийн хэргийг захиалгын хуудсын дагуу авч мэдээллийн сантай нэг бүрчлэн тулгаж, тусгаарлагдсан баримтуудыг ялган авсан ба цахим мэдээллийн санд зөрчилтэй 2184 бүртгэлийн зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт хийж зөрчлийг арилган ажиллалаа. Тооллогын явцад давхар бүртгэсэн зөрчилтэй 4 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж зөрчлийг арилгуулахаар хяналтын улсын байцаагчид хүсэлт хүргүүлээд байна. Хувийн хэрэг хаалгах материалыг нь хүлээн авсан боловч Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн хувийн хэргийг хаалгаагүй 2013, 2014, 2015 оны мэдүүлгүүдийг тусад нь тэмдэглэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Мөн EPRS2 программаас улсын бүртгэлийн дугаар алгасан унасан болон хилийн цэсийн улмаас өөрчлөгдсөн дугааруудыг тэмдэглэн авч нөхөж олгох асуудлыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэхээр жагсаалтыг үйлдэн ажиллаж байна.

Хөрөнгөгүй болон үл хөдлөх эд хөрөнгийн лавлагааны мэдүүлэг нотлох баримтыг 250 нэгж үүсгэн багцалж үдэн архивын санд байршуулсан.

Тус тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив нь сэлбэн засах шаардлагатай хувийн хэрэг баримтыг нөхөн сэргээх, сэлбэн засах ажлыг өдөр тутмын үйл ажиллагаагаараа тогтмол хийж хэвшсэн ба архивын хувийн хэргийн цэнхэр хавстыг сольж шинээр цаасан бор хавтсанд хийж 30752 хувийн хэргийн хаягийг сольж байрлуулаад байна.



Найм. Өргөдөл гомдол, мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаарх тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж ажиллалаа. Мөн улсын бүртгэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан тайланг хагас бүтэн жилээр гаргуулан авч дүгнүүлэн ажилласан.

Улсын бүртгэгч нар гэрчилгээ болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж хэлтсийн ахлах нягтлан бодогчоор хянуулж тооцоо нийлж ажиллаж хэвшсэн болно.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн 98, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 9, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 4, татварын хэлтсийн 1, төрийн байгууллагын 1 албан бичгийн хариу лавлагаа мэдээллийг хугацаанд хүргүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг тогтоол шийдвэрийн дагуу 73 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, 52 эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон байна. Мөн МИК-АКТИВ -27, 26, 28 ТЗК ХХК-ийн хүсэлтийн дагуу 41 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэлээ. Үнэт цаас санхүүжилтийн корпорацийн хүсэлтийн дагуу 123 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэл, хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж 2022 онд 13 чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, 9 хариутай, хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган хариуг хүргүүлсэн байна. Мөн хилийн цэсийн өөрчлөлттэй холбогдуулан 5 иргэний хүсэлтийг хүлээн авч хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан улсын бүртгэлийн гэрчилгээний улсын бүртгэлийн дугаар, хаягийн өөрчлөлтийн бүртгэлийг хийж гэрчилгээг сольж олгосон байна.

Ес. Тэмдэгтийн хураамж, үйлчилгээний төлбөрийн талаар:

Тайлант хугацаанд 9047 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээгээр 78 785 785 / далан найман сая долоон зуун наян таван мянга долоон зуун наян тав/ төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлсэн ба үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсны 2 хувь 252 264 400 / хоёр зуун тавин хоёр сая хоёр зуун жаран дөрвөн мянга, дөрвөн зуун/ төгрөгийг татварын орлогод, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө анх удаа бүртгүүлсний тэмдэгтийн хураамжинд 5 618 939 /таван сая хоёр зуун гучин арван найман мянга есэн зуун гучин есэн / төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Тус хэлтэс 2022.04.21-ний өдрөөс “Гэрэгэ” пос машин, 2022.05.06-ны өдрөөс “Киоск” машинаар тус тус үйлчилгээний хураамжийг авч байгаа бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамжаас бусад бүх үйлчилгээний хураамжийг “Гэрэгэ” пос машинаар карт уншуулан тушаалгаж хэвшээд байна.

5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэл нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, чиглэл, журмын хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт **754** иргэн хуулийн этгээдийн материал хүлээн авч ажилласан байна.

Нэг. Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:

Шинээр 211 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулан, шинээр үүсгэн байгуулагдсан 211 хуулийн этгээдийн материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэж хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өглөө. Үүнд:

Хязгаарлагдмал хариуцлагатай компани 149,

Хоршоо 25, дундын хоршоо 1,

Төрийн бус байгууллага 25,

Шашны байгууллага 2,

Салбар төлөөлөгчийн газар 4

Сан 2,

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 3-г тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.

Хоёр. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өөрчлөлт 479-г хүлээн авснаас:

Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар 196 /мэдээлэлд оруулсан өөрчлөлттэй давхардсан тоогоор/, хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн, хаяг, дүрмийн сан, гишүүн нэмэх хасах бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан 349, татан буугдсан 15-н хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өглөө.

Татварын ерөнхий хууль шинэчилсэн найруулга, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тус тус зааснаар хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэх ажилд 176 хуулийн этгээд бүртгүүлсэн байна. Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 05 дугаарын сарын 06-ны өдөр хоршооны хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан шинэ дүрмийг улсын бүртгэл 33 хоршоо бүртгүүлсэн байна

Гурав. Иргэн хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар:

Хуулийн этгээдийн лавлагаа

- Иргэн, хуулийн этгээдийн лавлагаа 116,

- Төрийн байгууллагад лавлагаа 27 нийт 143 лавлагаа олгосон байна.
- Хуулийн этгээдийн хувийн хэргээс хуулбар
- Иргэн, хуулийн этгээдэд хуулбар 25,
 - Төрийн байгууллагад хуулбар 25, нийт 50 хуулбар олгосон байна.

Дөрөв. Архив, мэдээллийн сан:

2022.11.30 байдлаар хуулийн этгээдийн архивт цахим санд бүртгэлтэй 2828, татан буугдсан 320 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3283 хуулийн этгээдийн хувийн хэрэг байршиж байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	31
2	Төрийн бус байгууллага	33
3	Хоршоо	2
4	Сан	4
5	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	24
6	Бүрэн бус хариуцлагатай компани	12
7	Шашны байгууллага	7
8	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	18
9	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	1
10	Хувиараа эрхлэх аж ахуй	1
11	Нөхөрлөл	2

Цахим санд бүртгэлтэй 2828 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хувьцаат компани	10
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1733
3	Төрийн өмчит хувьцаат компани	1
4	Орон нутгийн өмчит хувьцаат компани	0
5	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	2
6	Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	73
7	Боловсрол сургалтын байгууллага	1
8	Төрийн бус байгууллага	331
9	Хоршоо	306
10	Хадгаламж зээлийн хоршоо	7
11	Төрийн байгууллага	232
12	Сан	14
13	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3
14	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	57
15	Шашны байгууллага	27
16	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	14
17	Банк бус санхүүгийн байгууллага	2
18	Татан буугдсан	320

Тав. Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох:

2022 оны 11 сарын 25-ны байдлаар иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу 298-н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож, шинээр хуулийн этгээдэд тамга тэмдэгийг хяналтын дугаар олгосон 211, ашиглалтын шаардлага хангахгүй болсон дахин хяналтын дугаар авсан 41, татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан 46 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгэнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Зургаа. Мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Сар бүрийн 25-наар тасалбар болгон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээ, архивын орлогын мэдээг батлагдсан маягтын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох албан тушаалтанд цахимаар болон цаасаар хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хариутай албан бичгийг тогтоосон хугацаанд холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны байдлаар шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг хүргүүлсэн байна.

2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар E-Mongolia төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл системд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, хуулийн этгээдийн цахим гэрчилгээ болон шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах зэрэг 784 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна

Долоо: Орон нутгийн болон бүртгэлийн хэлтсийн дансанд төвлөрүүлсэн үйлчилгээний хураамж:

Орон нутгийн дансанд шинээр үүсгэн байгуулагдсан болон хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт, лавлагааны үйлчилгээний хураамж болох 13.191.500 / арван гурван сая нэг зуун ерэн нэгэн мянга таван зуу/-н төгрөг, улсын бүртгэлийн дансанд хуулбар, нэрийн баталгаажуулалтын үйлчилгээний хураамж 833.500 /найман зуун гучин гурван мянга таван зуу/-н төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Найм. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ажил:

2022 оны 01 дүгээр сарын 19-нд сумдын албан хаагчдад төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлт болон 2022 оныг хоршоог дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хоршооны шинэчилсэн дүрмийн онцлог зохицуулалтын талаар Мөрөн сумын ЗДТГ-ын аобан хаагчдад мэдээлэл өгөв.

Мөрөн суманд 209, бусад сумдад 66 нийт аймгийн хэмжээнд 275 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн төрийн бус байгууллагыг 23-н сумаар нь ялган excel файл үүсгэн сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 66 төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 209 төрийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нарт тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар утсаар зөвөлгөө өгч Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн faje хуудас, Хөвсгөл аймгийн хэмжээний төрийн бус байгууллагын нэгдсэн face групп / Хөвсгөл ТББ/-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэх тухай мэдээлэл, тайлангын загвар маягтыг тус тус байршуулан, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайлан ирүүлэх хуулийн хугацаанд 58 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэн архивт хүлээлгэн өглөө.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын тулд утсаар давхардсан тоогоор 1024 гаруй иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч, оноосон нэрийн хүсэлтийг утсаар авч шүүн 226 мессежэнд хариу илгээж, хуулийн этгээд шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэхтэй холбоотой загвар маягтыг сумдын улсын бүртгэгчээр дамжуулан иргэдэд хүргүүлж хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй авах нөхцөл боломжоор ханган, зарим тохиолдолд үйлчилгээнд ашиглагдаж байгаа загвар маягтуудыг цахим шуудангаар илгээн ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг бүхий мэдээллийн самбарыг байгууллагын байрны үйлчилгээний зааланд байршуулан, хуулийн этгээдийн хөтөч хавтас шинэчилж иргэдэд мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах мөн E-Mongolia цахим системд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, цахим гэрчилгээний талаар мэдээллийг иргэдэд цахимаар түгээн ажиллаж байна.

Ес. Бусад ажил

Хөвсгөл гурил тэжээл ХХК нь хувьцаа эзэмшигчдийн маргаантай байгаа асуудлаар:

1.Цагдаагийн байгууллагад эрүүгийн 1838009120300 дугаартай хэрэг /Хөвсгөл гурил тэжээл ХХЗ-ны тамгатай холбоотой/ хэрэг хянан шалгах ажиллагаа явагдаж байна.

2. Хяналтын улсын байцаагч Т.Золбаярын дүгнэлтээр /хуурамч баримт бичиг үйлдэж бүртгэл хийсэн байж болзошгүй гэх үндэслэлээр Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулах/

3. Иргэн Л.Ганбатын нэхэмжлэлтэй “Хөвсгөл гурил тэжээл ХХК-ийн ТТБ2580 дугаартай тэмдгийг хүчингүйд тооцсон захиргааны акт гаргахыг даалгах” тухай Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар хэрэг үүсэн шалгагдаж байна.

Мөн Хөвсгөл гурил тэжээл ХХК-тай холбоотой иргэн болон хуулийн этгээд, хууль хяналтын байгууллага итгэмжлэгдсэн, төлөөлөгч нарт архив болон цахим мэдээллийн сангаас хуулбар, лавлагаа, албан тоот, хариу бичгийг цаг тухай бүрт нь гарган ажиллаж байна.

Арав. Төрийн байгууллагын хамтын ажиллагаа

Аймгийн Татварын хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Статистикийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж шинээр бүртгэгдсэн болон татан буугдсан аж ахуй нэгжүүд, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа зэргийг улирал тутам тулган баталгаажуулан ажиллаж байна.

Хоршоодын дэмжих жил болгон заралсантай холбогдуулан Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Аймгийн ЗДТГазар, Хоршоологчдийн хамтарсан ажилын хэсэгт Хуулийн этгээд бүртгэгч ажлын хэсэгт орон ажиллаж байна.

2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Хөвсгөл аймгийн ЗДТГазар болон орон нутгийн өмчийн хороотой хамтран сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага албан газрын удирдлагуудад “Хуулийн этгээдийн гэрчилгээнд мэдээдэлд өөрчлөлт оруулах” талаар сургалт заавар зөвлөгөө өгөн ажилласан. Мөн дээрх сургалт 05 дугаар сарын 12-ны өдөр дахин зохион байгуулагдаж Хөвсгөл аймгийн УБХ-г төлөөлөн “Тоон гарын үсэг”, “Эцсийн өмчлөгч”, “Хоршоодын шинэчилсэн бүртгэл”, “Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй ТБАГ”-ын мэдээлэлд өөрчлөлт оруулах талаар сургалт хичээл орсон.

2022 онд хоршоог дэмжих жил болгон зарласантай холбогдуулан Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газраас 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 1/95 тоот албан бичгээр Хөвсгөл аймагт бүртгэлтэй хоршоодын судалгааг хүргүүлэн хамтран ажилласан.


2022 оны 10 дугаар сарын 28-нд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын засаг даргын тамгын газар болон Хөвсгөл аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөвсгөл аймгийн хоршоологчдын холбоотой хамтран хоршоодын гишүүдэд сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэв.

2022 оны 11 дүгээр сарын 29-ны 1/1333 тоот албан бичгээр Хөвсгөл аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газарт Хөвсгөл аймагт бүртгэлтэй хоршоодын судалгааг хүргүүлэв.


Орон нутгийн өмчийн тооллогтой холбоотой Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй Төрийн байгууллага албан газрын хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөлт, хөрөнгийн хэмжээ, гүйцэтгэх удирдлага зэрэгмэдээллийн сан зөрүүтэй 230 гаруй хуулийн этгээдийн мэдээллийг хүлээн авч 194 хуулийн этгээдийн мэдээллийг засаж бүртгэсэн байна.

**Арван нэг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сүүлийн 5н жилийн мэдээг
графикаар харьцуулбал:**


**2018- 2022 ОНЫ БАЙДЛААР ТАМГАНЫ ХЯНАЛТЫН ДУГААР ОЛГОСОН
БАЙДАЛ**




2018-2022 ОНЫ ЖИЛД ШИНЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД



2018-2022 ОНД ТАТАН БУУГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД



2018-2022 ОНД ХИЙСЭН БҮРТГЭЛИЙН ТОО



6. ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2022 оны хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2022 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Тус хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, журам, дүрэм, заавруудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж нийт 2352 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

Улсын бүртгэлийн алдаа, зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн хяналтын оператор өөрийн чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийх замаар алдаа, зөрчлийг илрүүлж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд улсын алхах бүртгэгч, улсын бүртгэгч, улсын бүртгэлийн байгууллагын бусад ажилтан холбогдох эх нотлох баримт бичиг, жагсаалтыг гаргаж өгөх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий программ хангамж, техник, технологийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүртгэлийн талаар нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зэргээр хамтран ажиллалаа.

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийж, илрүүлсэн алдаа, зөрчлийн талаарх мэдээг сар бүр гарган, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-1643, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-367, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-122, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-220 тус тус шалгаж ажиллалаа. Шалталтын явцад нийт 196 зөрчил илэрсэн бөгөөд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-138, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-50, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-8, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-0 тус тус зөрчил илэрсэн байна. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт тайлант хугацаанд 125 гарсан бөгөөд үүнээс Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-69, Хуулийн этгээдийн чиглэлээр-4, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-52 дүгнэлт гарган ажилласан байна.

Зөрчлийн хуулиар 221 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд торгууль оногдуулсан хүн-215, торгууль оногдуулсан хуулийн этгээд-6 торгууль, шийтгэх хуудас бичиж Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд 9240000 төгрөгийн орлого оруулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу тус аймгийн Улсын бүртгэлийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалж үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ны өдрийг дуустал хяналт, шалгалт хийж гүйцэтгэв. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан эсэхийг шалгахад нийт 105 иргэн, хуулийн этгээдээс 70 хүнсний дэлгүүр, 10 зочид буудал, 17 эм ханган нийлүүлэх газар, 4 барьцаалан зээлдүүлэх газар, 4 ТҮЦ зэрэг иргэн, хуулийн этгээдийг шалгахад ямар нэгэн зөрчил илэрсэнгүй. Дээрх иргэн, хуулийн этгээдэд энэ төрлийн зөрчил гаргахгүй байх, иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалбал “Зөрчлийн тухай хууль”-ийн 15.24-2 д заасан торгуулийн арга хэмжээ авах хууль тогтоомжийн зарим зүйл заалтын талаар мэдээ мэдээлэл өглөө.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд нь иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ зэргийг авдаггүй энэ бол хоцрогдсон явдал гэх мөн иргэний үнэмлэхийг амьтай болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг талаар санал гомдлоо хэлж байлаа. Мөн Улсын бүртгэлийн байгууллагаас шалгахаас гадна тус аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагаас тогтмол үзлэг, хяналт шалгалт хийж хэвшсэн тул дээрх төрлийн зөрчил гаргахгүй байх тал дээр иргэн, хуулийн этгээд анхаарч ажилладаг болсон байна.

Хяналт шалгалтын үеэр иргэн, хуулийн этгээдэд “Улсын бүртгэлийн ерөнхий хууль” болон Зөрчлийн тухай хууль”, “ Гэмт хэрэг, зөрчлөөс урдчилан сэргийлэх тухай хууль” зэрэг хуулиудын талаар мэдээлэл өгч, иргэн, хуулийн этгээдийн хүлээсэн үүргийг танилцуулах ажлыг зохион байгуулан мөн тоон гарын үсгийн талаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж”-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хяналтын улсын байцаагч нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 01-нээс 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэлх бүртгэлийг шалгаж ажиллалаа. Энэхүү шалгалтаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан Хяналт шалгалтын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 дах заалтад заасан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх” ажлыг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллалаа. Удирдамжид заасан хугацааны бүртгэлийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын алхах бүртгэгч, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын алхах бүртгэгч, Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс татан авч ,бүртгэл тус бүрээр улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг EPRS-2 программаас мета дата буюу бүртгэлийн төрлөөр цахимжсан эсэх, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийг ERS программаас үйлчилгээний нэршил зөв орсон эсэхийг тус тус нотлох баримттай нэг бүрчлэн тулгалаа.

Шалгалтын хугацаанд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл-222, эцэг /эх/ тогтоосны бүртгэл-13, үрчилсний бүртгэл-5, ургийн овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-10, гэрлэсний бүртгэл-47, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-10, нас барсны бүртгэл-79, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр шинэ-247, 25,45 насны сунгалтаар-244, дахин авахаар-105, үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл-200, шилжилт хөдөлгөөний бүртгэл-212, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 241 бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 52 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсаныг тулгаж шалгасан байна. Тус хяналт шалгалтаар Иргэний улсын бүртгэлээс 11-н зөрчил, Эд хөрөнгийн улсын эрхийн бүртгэлээс 8-н зөрчил, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлээс 3-н зөрчил тус тус илэрлээ. Илэрсэн зөрчлийн ихэнх нь нотлох баримт үнэн зөв, бүрэн боловч цахимжуулах явцдаа нэршил буруу, скайнердах шаардлагагүй баримт бичиг скайнердсан, нэршлээ сольсон зэрэг алдаа дутагдал илэрсэн ба зөрчлийг нэн даруй арилгаж, хууль, журамд нийцүүлэх арга хэмжээ авч ажиллахыг улсын бүртгэгч нарт анхааруулан зөвлөгөө өгч шалгалтын илтгэх хуудсыг тогтоосон хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллалаа.

Хоёр. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр


Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд Галт, Тариалан, Түнэл сумын иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нотлох баримтыг хуульд зааснаар бүрдүүлэн авах, мэдээллийн санд үнэн зөв бүртгэх эсэх талаар шалгалт хийж тайланг хүргүүллээ.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1643 бүртгэлд хяналт тавьж, 69 дүгнэлтээр 223 иргэний зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгасан.

Хяналтын байцаагчийн дүгнэлтээр:

- Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай - 28
- Бүртгэл хүчингүй болгох -8
- Бүртгэлд засвар өөрчлөлт хийх тухай - 30
- Регистрийн дугаар хүчингүй болгох тухай - 2
- Бүртгэл сэргээх - 3

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд Галт, Тариалан, Түнэл сумын сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан ажлын хүрээнд хяналт тавьж ажилласан байна.




Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажилласан бөгөөд хяналт тавьсан 367 бүртгэлээс 52 бүртгэлд гэрчилгээ хүчингүй болгох, бүртгэлд өөрчлөлт оруулах талаар дүгнэлт гаргасан.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан зөрчил нь:

- Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох - 47
- Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай - 5


Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2022.03.09-ний өдрийн 6/2010 дугаартай чиглэл, хяналтын улсын байцаагчийн 2022.03.02-ны 1500 дугаартай дүгнэлт, улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газрын 2022.04.07-ны өдрийн 7/2971 дугаартай чиглэлийн дагуу мэдээллийн санд зөрчилтэй 489 хувийн хэргийг архивын эх нотлох баримттай тулган, засвар өөрчлөлт оруулсныг тухай бүр хяналт тавин ажиллаж байна.



Дөрөв. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар 122 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажилласан бөгөөд хяналт шалгалтаар 4 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан байна.

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллалаа.



Тав. Архив, мэдээллийн сангийн чиглэлээр:

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж байна. Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 220 лавлагаанд хяналт тавьж ажиллалаа. Мөн байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаагаагр хэлтсийн 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд ИУБ-21 маягт 9250ш захиалгын хуудас 2500ш нэр төрлийн баримт бичгийг устгасан.

Зургаа. Өргөдөл гомдол, мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд хяналт шалгалтын талаарх тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон улсын бүртгэлийн газарт хүргүүлж ажиллалаа. Мөн хилийн цэсийн өөрчлөлттэй холбогдуулан 3 иргэний хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлийн гэрчилгээний улсын бүртгэлийн дугаар, хаягийн өөрчлөлтийн дүгнэлт гарган ажиллалаа

7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтэс нь 2021 оны жилийн эцсийн тайлангийн аудитаар “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт авч УБЕГазарт нэгтгүүлсэн. Тайлантай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгч Аймгийн Аудитын газартай хамтран ажилласан.

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг УБЕГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу орлогын нэр төрөл, мөнгөн хөрөнгийн данс бүрээр, өглөг авлагын задаргаа бүрээр цаг хугацаанд чанартай гарган УБЕГазарт хүргүүлэн, Шилэн дансны сайт, Хөвсгөл УБХэлтсийн мэдээллийн сайт, байгууллагын “Санхүүгийн ил тод байдлын” самбарт нээлттэйгээр байрлуулан ажиллаж байна. Мөн Шилэн дансны сайтад Улсын тэмдэгтийн хураамжийн шинэчлэгдсэн хураамж, 2021 оны аудитын дүгнэлт, 2022 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд нь байршуулсан.

Бүртгэгч нарын 2022 оны 1-11 сарын үнэт цаасны кодтой тайланг хугацаа хоцроолгүй нэгтгэн УБЕГазрын санхүүгийн хэлтэст хүргүүлээд байна. Энэ хугацаанд УБЕГазраас 47 нэр төрлийн 67964 ширхэг 22 787 155 төгрөгийн үнэт цаас үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэгчдэд олгон УБЕГ-н даргын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн а/707 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягт хүлээн авах, олгох, зарцуулалтад хяналт тавих журам”-ын дагуу тайланг сар бүр авч тайланг нэгтгэж байна.

Төрийн өмчийн тооллогыг ажлын хэсэг гарган нэг бүрчлэн тоолж, тооллогын тайланг байгууллагын өмч хамгаалах зөвлөлд актлах болон дахин үнэлэх хөрөнгүүдийн жагсаалтыг танилцуулсан. Үүний дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн №002 дүгнэлтээр 9 нэр төрлийн 14 ширхэг 27 518 865.58 төгрөгийн үнэ бүхий 27 518 865.58 төгрөгийн элэгдэлтэй машин тоног төхөөрөмж, 11 нэр төрлийн 15 ширхэг 4 453 650.00 төгрөгийн үнэ бүхий 4 453 650.00 төгрөгийн элэгдэлтэй тавилга эд хогшлыг ашиглалтын хугацааг сунгаж дахин үнэлэх, мөн цаашид ашиглахааргүй болсон анхны үнээ бүрэн нөхсөн элэгдэл нь дууссан 14 нэр төрлийн 21 ширхэг 20 203 443.36 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 3 ширхэг 520 000.00 төгрөгийн тавилга эд хогшлыг актлах саналыг УБЕГазарт хүргүүлээд байна.

2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан балансыг зохих хууль журмын дагуу гарган УБЕГ-т хүргүүлж, хянуулан Сангийн яамны э-тайланд шивж баталгаажуулсан. 2022 онд батлагдсан 682 432 500 төгрөгийн төсвөөс 11 сарын байдлаар 617 646 800 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсны 533 905 405 төгрөг буюу нийт зардлын 89%-г цалин НДШ-ийн зардалд зарцуулсан байна. Мөн Багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас архивын тавиур гагнуулж хийлгэхэд 1 800 000 төгрөг, заалны чимээ багасгаж дуу намсгахад зориулж 5 акустка хавтанг 510 000 төгрөгөөр худалдан авч албан хаагчдыг дотоод нөөц бололцоогоороо өөрсдөө хийж гүйцэтгэсэн.

2022 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 250 000 000 төгрөгийн орлогын төлөвлөгөө өгснөөс 191 048 933 төгрөгийн орлого оруулж төвлөрүүлэн орлогын гүйцэтгэл 11 сарын байдлаар 76.4%-тай байна.

Тус хэлтэс нь 2022 онд батлагдсан 47 орон тооноос жирэмсэн амаржсан болон ажлаас чөлөөлөгдсөн 3 албан хаагчийн орны томилгоо хийгдээгүй холбоотой цалингийн зардлаас 9 067 000 төгрөгийг хэмнээд байна.

Албан хаагчдын цалинг цалингийн нэгдсэн системээр бодож Нийгмийн даатгалын тайланг PAYROLL цалингийн программаас татан, ХХОАТ-н тайланг цалингийн нэгдсэн сангаас татан оруулж, нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өргүй ажиллаж байна.

УБЕГын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 8/4645 албан бичгээр ирүүлсэн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх зөвлөмжийг мөрдөн ажиллаж албан томилолтын зардалгүйгээр зөвхөн шатахууны зардал гарган 14 суманд тоон гарын үсэг олгох ажил болон алслагдсан 3 сумын 284 иргэний монгол улсын энгийн гадаад паспортын захиалга авч 9 230 000 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал оруулан 2 ширхэг иж бүрэн киоск 54 000 000 төгрөгөөр шийдвэрлүүлэн иргэдэд хүргэх үйлчилгээг улам шуурхай чирэгдэлгүй болгон үйлчлүүлэгч иргэдийн талархлыг хүлээж байна. Тус хэлтсийн 2023 оны төсвийн төслийг хийж УБЕГазарт хүргүүлсэн бөгөөд хэлтсийн конторын барилгын их засварын төсвийг Грэйн пайнт тийм компаниар хийлгүүлэн УБЕГазарт хүргүүлсэн.

8. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Хэлтсийн нярав, бичин хэргийн ажилтан нь байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Тус хэлтэс нь тайлант хугацаанд 1344 албан бичгийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажлласан бөгөөд 1429 албан бичгийг хүлээн авч, хэлтсийн нийт бичиг хэргийн эргэлтийн тоо 2763 болсон байна. Хүлээн авсан 1429 албан бичгээс 988 нь хариутай албан бичиг байсан ба холбогдох хариуг цаг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 34 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 12, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 22-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 42 өргөдөл, гомдол ирсэн ба өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, шийдвэрлүүлж, 1 өргөдөл гомдлын шийдэвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. ABLE программд нийт дотоод албан бичиг 75 ирсэн ба 180 албан бичиг явуулсан байна. Khuvsgul@burtgel.gov.mn хаягаар 599 албан бичиг ирсэн ба 522 албан бичиг явуулсан бол орон нутгийн uburtgel@khs.gov.mn хаягаар 115 албан бичиг ирсэн, 72 албан бичиг тус тус явуулсан байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд тоон гарын үсэг ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан Able програмаар хүргүүлж, бичиг хэргийн зардлыг хэмнэн ажиллаж хэвшсэн байна. Хэлтсийн байгууллагын архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэл хадгаламжийн нэгжүүдийг оноор, оны дотор хадгаламжийн нэгжүүдийг баримтын ач холбогдлоор нь дараалуулан байрлуулж, хадгаламжийн хугацаа дууссан баримт бичгийг устган ажилласан болно.

Хэлтсийн албан бичгийн жилийн эцсийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2020 оны жилийн эцэс	650	600	1250	1600	19	7	26	95
2021 оны жилийн эцэс	550	231	781	1452	17	10	27	79
2022 оны жилийн	988	441	1429	1344	12	22	34	42

Албан бичгийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 14
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой – 0
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 25
- Албан хаагчтай холбоотой гомдол – 0
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 1
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 0

Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдлаар нь задалбал:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 14
УБЕГ ИУБГ- т санд өөрчлөлт оруулахаар хүргүүлсэн 6
Албан бичгээр хариу өгсөн 1
Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 7
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 2
Хуульд заасны дагуу хариу лавлагаа өгөх боломжгүй 1
Эд хөрөнгийн лавлагаа авах эрхгүй байсан 1
- Бүртгэл хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 25
Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 22
Албан бичгээр хариу өгсөн 1
УБЕГ-ын ИУБГ-т санд өөрчлөлт оруулахаар 1
Хэлж тайлбарласан 1
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 1

9. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Хэлтэст авч хэрэгжүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 29, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 51 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн Монгол хэл бичгийн сургалт болон Тагнуулын байгууллагын сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан. Тус хэлтэс нь улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хэлтсийн даргаар “Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, хөрвөх чадвартай улсын бүртгэгч бэлтгэх” сургалтын төлөвлөгөөг батлуулан, 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс тайлант хугацаанд хүртэл хуваарийн дагуу 15 сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.

1.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй сургалт:

- 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Аз жаргалтай ажиллахын нууц сургалтанд хэлтсийн нийт албан хаагч 90% буюу 38 албан хаагч
- 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал зохицуулах харилцааны талаарх сургалтад 40 албан хаагч
- 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Орчин үеийн хөгжлийн мегатрэндүүд сургалтанд 39 албан хаагч
- 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Монгол орны хөгжлийн хэтийн төлөв сургалтанд 36 албан хаагч
- 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинд хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам сургалтанд 38 албан хаагч хамрагдсан байна.
- 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн Албан ёсны статистик ба их өгөгдөл сургалтанд 40 албан хаагч
- 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Манлайлалын хэв маяг хандлагаа тодорхойлох нь сургалтанд 42 албан хаагч
- 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн харилцан адилгүй үеийнхнийг үр дүнтэй манлайлах нь сургалтанд 35 албан хаагч хамрагдсан
- 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Хүлээлтийн гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь сургалтанд 38 албан хаагч
- 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь сургалтанд 36 албан хаагч
- 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн Гүйцэтгэл сайжруулах сеучинг сургалтанд 38 албан хаагч
- 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Төрийн байгууллагын бүтээмж сургалтанд 42 албан хаагч

- 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Чанарын менежментийн тогтолцоо сургалтанд 35 албан хаагч
- 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн сургалтанд 39 албан хаагч
- 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга онцлог зохицуулалт сургалтанд 36 албан хаагч
- 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин ёс зүйн үзэл ёс суртахууны төлөвшил сургалтанд 35 албан хаагч
- 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин ёс зүйн үзэл ёс суртахууны төлөвшил сургалтанд 35 албан хаагч
- 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх сургалтанд 39 албан хаагч
- 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Бүтээлчээр хурдан уншихуй сургалтанд 38 албан хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Бүтээлчээр хурдан уншихуй сургалтанд 38 албан хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Монголчууд 20-р зуунд сургалтад 39 албан хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Төрийн алба шинэ сорилтууд сургалтад 36 албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Төрийн удирдлага системт шинжлэх ухаан болох нь сургалтад 38 албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн албан хаагчийн ёс зүй сургалтад 35 албан хаагч
- 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Монгол улсын үндэсний болон гадаад аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлууд сургалтад 40 албан хаагч
- 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Стресс менежмент сургалтад 38 албан хаагч
- 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Монголын тусгаар тогтнолын үнэ цэн сургалтад 36 албан хаагч
- 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Монгол бичгийн үнэдсний хөтөлбөр 3-ын хэрэгжилтийн явц сургалтад 34 албан хаагч тус тус хамрагдсан

2. Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан сургалт:

- 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын Хууль-Эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын танилцуулах сургалт
- 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Эрх зүйн сургалтанд албан хаагчид хамрагдсан байна.
- УБЕГ-ын ЭХЭУБГазраас 2022 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан онлайн сургалт
- 2022 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд УБЕГ-аас удирдах албан тушаалтны сургалт ба тоон гарын үсгийн сургагч багш бэлтгэх сургалтад 3 албан хаагч хамрагдсан байна.
- 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Хуурамч бичиг баримт түүнээс урьдчилан сэргийлэх тухай сургалтанд хамрагдсан байна.
- 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Тоон гарын үсгийн хэрэглээнд нэвтрүүлэх практик сургалтад албан хаагчид бүрэн хамрагдсан байна.
- 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрар болон Татварын ерөнхий газарын хамтарсан хуулийн этгээд бүртгэгч нарт зориулсан сургалтанд хамрагдсан.
- 2022.05.30-ны өдөр Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулж буй “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны үйл ажиллагааг хялбаршуулах хүрээнд Авлигатай тэмцэх газрын урьдчилсан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй цахим уулзалтанд улсын бүртгэгч Б. Цэнд-Аюуш оролцсон.
- 2022 оны 06 дугаар сарын 08-нд E-Mongolia програмаар хэрхэн бүртгэл хийх тухай УБЕГ-ын сургалтанд 23 албан хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 16-нд ЗДТГазраас “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд Засаг даргын Тамгийн газрын хууль эрх зүйн хэлтсийн сургалтанд хамрагдав.
- 2022 оны 06 дугаар сарын 21-нд Хөвсгөл аймгийн ЗДТГ хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан Авилга авилгын шалтгаан нөхцөл хор хөнөөл “Авлид үгүй гэж хэлье” сургалтанд хамрагдав.
- 2022 оны 06 дугаар сарын 22-нд УБЕГ-аас зохион байгуулсан тоон гарын үсгийн тухай сургалтанд 25 албан хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 28-нд УБЕГ-аас шилжилт хөдөлгөөний бүртгэлийг E-Mongolia систэмээр бүртгэх тухай онлайн сургалтанд 15 алба хаагч
- 2022 оны 06 дугаар сарын 30-ны Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нарт зориулан” зохион байгуулсан сургалтанд улсын ахлах бүртгэгч Д. Чимэдцогзол онлайнаар оролцлоо.
- 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр УБЕГ-ын Эрх зүйн сургалтанд 28 албан хаагч
- 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдөр И-Монгол академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын цахим засаглалын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт”-нд хэлтсийн албан хаагчид

- 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Төрийн албан хаагчдийн цахим засаглалын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хэлтсийн албан хаагч
- 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Архив бичиг хэрэг хөтлөлтийн сургалтанд 3 албан хаагч байна.
- 2022 оны 09 дүгээр сарын 20-нд “Авилга,ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ”, “Үйлчилгээгээ хялбаршуулъя” зэрэг сургалтанд хамрагдав.
- 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Албан хаагдын хууль, эрх зүй, практик хэрэглээг нэмэгдүүлэх” цахим сургалт
- 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газрын Соёмбо танхимд “Авлигатай тэмцэх газар”-аас зохион байгуулсан сургалтанд тус тасгийн улсын бүртгэгч Ө. Батнасан
- 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар хамтран зохион байгуулсан “Авлигын эсрэг анхан шатны онлайн сургалт”
- 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Хүний эрхийг хангах болон хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаарх” сургалт
- 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн “Хүний эрхийг хангах болон хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаарх сургалт”-д хэлтсийн бүх албан хаагч хамрагдсан.
- 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан “Хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн сан, программын танилцуулга сургалт”-д хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий, мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа нар хамрагдсан.
- 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Оюуны дасгалжуулагч багш Дэнсмаа, Нямханд нарыг урин авчирч “Хувь хүний хөгжил, эрүүл мэнд, гоо сайхан” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагч
- 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Дэлхийн зөн олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Үр дүнтэй удирдахуй” сэдэвт сургалтанд улсын ахлах бүртгэгч Д. Чимэдцогзол
- 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад зориулсан” онлайн сургалт
- 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчиланг сэргийлэх” онлайн сургалтад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг
- 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрх зүйн хэлтэс, Хамтын ажиллагаа сургалтын хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Терроризмтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт онлайн сургалтанд тасгийн улсын бүртгэгч, улсын ахлах бүртгэгч нар тус тус хамрагдлаа.

3. Улсын бүртгэлийн хэлтсийн дотооддоо зохион байгуулсан сургалт:

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хэлтсийн даргаар “Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, хөрвөх чадвартай улсын бүртгэгч бэлтгэх” сургалтын төлөвлөгөөг батлуулан, 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс тайлант хугацаанд хүртэл хуваарийн дагуу 15 сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.

- 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн Далай ван дээд сургуулиас Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь дахь хэцүү бичлэгтэй үгийн учир сэдэвт сургалтанд 15 албан хаагчид хамрагдсан
- 2022 оны 03 дугаар сарын 22-ний өдөр Хөвсгөл аймаг дахь Тагнуулын газраас Төрийн нууц тухай хууль тогтоомж анхаарах асуудал сургалтад 16 хэлтсийн албан хаагчид хамрагдсан байна.
- 2022 оны 04 дүгээр сарын–ны өдөр Дэмчэр гүн ХХК-ны ХАБЭА-гийн сургалтын багшийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сэдэвт сургалтанд хэлтсийн 19 албан хаагч хамрагдаж оролцсон байна.
- 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хяналтын улсын байцаагч сумдын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж 23 албан хаагчид хамрагдсан байна.
- 2022 оны 05 дугаар сарын 18-нд сумдын улсын бүртгэгч нарт хяналтын улсын байцаагч сумдын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж 23 албан хаагчид хамрагдсан байна.
- 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр “Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, иргэний улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэл” сэдэвт сургалтыг иргэний улсын бүртгэгч Б.Дуламсүрэн, Мөрөн сумын улсын бүртгэгч П.Даваадулам нар
- Анхны бүртгэл / Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд анх удаа бүртгүүлэх газар өмчлөх, шинээр баригдсан үл хөдлөх эд хөрөнгө/ бүртгүүлэхэд бүрдүүлэх материал болон бүртгэлийг хэрхэн хөтлөх талаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол
- Хоршооны шинэчилсэн бүртгэл болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч бүртгүүлэх талаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч Н.Азжаргал
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий
- Оффисын хэрэглээний программ /Word, Excel, PowerPoint/ тухай мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа
- Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар иргэний улсын бүртгэгч Б.Батжаргал, Мөрөн сумын улсын бүртгэгч Б.Бямбажав нар
- Гэрээний бүртгэл /Худалдах худалдан авах гэрээ, бэлэглэл, өв залгамжлалын бүртгэл/-ийн талаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг

- Шинээр хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх талаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч Н.Азжаргал
- Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн талаар хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий
- Дотоод сүлжээнд ашиглагддаг программын хэрэглээ болон, дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах тухай мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа
- Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, архив иргэний улсын бүртгэгч Б.Мөнхжаргал, иргэний баримтын архивч Б.Оюунцэрэн
- Өөрчлөлт залруулга /Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд хэмжээ, хаяг, зориулалт гэх мэт өөрчлөлтийн бүртгэл/ талаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг
- E-Mongolia-аар хуулийн этгээдийн нэр баталгаажуулах бүртгэл, цахим гэрчилгээ талаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч Н.Азжаргал
- Мэдээллийн аюулгүй байдлын тухай Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн ахмад Г.Түмэнжаргал нарын сургалтад хэлтсийн бүх албан хаагч хамрагдсан.

10. ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллалаа. Цаашид улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд улам ойртуулахад суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхөд анхаарч 2022 оны сүүлээр эрх зүйч мэргэжлээр сурч төгсөх 6 сумын улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөх эрх олгох, удирдлага арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна

Улсын төсөв төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 76.4 хувьтай байгаа нь E-Mongolia төрийн үйлчилгээ нэвтэрсэнтэй холбоотой тус хэлтэст орох орлого багассан, мөн 2 ширхэг киоск машинаас иргэний бүртгэлийн 12 төрлийн лавлагаа үнэ төлбөргүй гарч байгаа зэргээс орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэл үүсч байна. Мөн энэ онд бүртгэлийн тоо цөөрсөн, арилжааны банкууд барьцааны зээл олголт 2021 оны мөн үеийнхээс 23.6 хувиар буурсантай холбоотой гэж үзлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тус хэлтсийн барилгын их засварын зураг, төсвийн дагуу 478.0 сая төгрөгийн их засварын зардлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн яам, УИХ гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар, УИХ гишүүн Л.Энх-Амгалан, УИХ-н гишүүн Ц.Даваасүрэн нарт хүсэлтийг нийт 8 удаа уламжилж байгаа бөгөөд цаашид шийдвэрлүүлэхээр ажиллах шаардлагатай байна.

Монгол улсын хэмжээнд Цахим гарын үсгийн тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хэрэгжиж эхэлсэн. Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан. Уг хуулийн хэрэгжилтийг ханган Улсын бүртгэлийн ерөнхий газраас батлагдсан тоон гарын үсэг олгох төлөвлөгөөний дагуу хэлтсийн төлөвлөгөөг 7 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж, аймгийн хэмжээнд нийт 24372 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. 2023 оны төлөвлөгөөнд иргэдэд тоон гарын үсэг олгох үйл ажиллагаанд хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах, алслагдсан сум, багийн иргэдэд хүрч үйлчлэх зорилттой ажиллахаар байна. Гэвч байгууллагын автомашин ашиглалтын шаардлага хангахгүй эвдэрч сум руу явж ажиллахад хүндрэлтэй байгаа тул албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор албаны машиныг актлах, туулах чадвар өндөртэй автомашиныг шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, төлөвлөсөн 30 арга хэмжээг хяналтандаа авч, мөн нэмэлтээр 2 ажлыг гүйцэтгэлийн тайланд тусган хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна. Хэлтсийн зүгээс гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100% хэрэгжүүлэн ажилласан гэж дүгнэж байна.

Цаашид “Алсын хараа 2050”-ын Засаглалын бодлогод Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг тогтвортой засаглал тогтоож, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжин, улмаар хүний эрхийг бүрэн хангасан шударга ёсны тогтолцоо төлөвшсөн авлигагүй улс болох зорилтын хүрээнд 2023 оны төлөвлөгөөнд Улсын бүртгэлийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран, хөрөнгө санхүүгийн хэмнэлттэй, ил тод шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтыг ханган ажиллах болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН

Э.НАРАНТУЯА

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНЗУЛ